

Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид статус нь цөмийн зэвсэггүй бүсийн дэглэмийг тэлэн бэхжүүлэх арга зам мөн

Жаргалсайханы Энхсайхан

Доктор (Ph.D), Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд, enkhhee53@yahoo.com

“Монгол Улс бол зөрчил тэмцэлтэй дэлхийд энх тайвны

бэлгэ тэмдэг болсон улс мөн.”

НҮБ-ын ЕНБД А.Гутерреш

“Монгол Улс ... цөмийн зэвсгээс ангид байх бодлого, үйл ажиллагааг цаашид ч тууштай даган мөрдөж, дэмжихээ дахин нотолж байна.”

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх

Хураангуй

Энэхүү өгүүлэлд Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид статусыг олон улсын цөмийн зэвсэггүй бүс (ЦЗБ)-ийн дэглэмийг шинэ нөхцөлд өргөтгөн бэхжүүлэх өвөрмөц загвар болохыг түүхэн болон олон улсын эрх зүйн үүднээс шинжилсэн болно. Судалгаанд Монгол Улс 1992 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн индэр дээр энэхүү санаачилгыг дэвшүүлснээс хойших үйл явц, НҮБ-ын гүйцэтгэсэн үүрэг, Ерөнхий Ассамблейн тогтоолуудын ач холбогдол, Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх гэрээний (NPT) эрх зүйн орчин, цөмийн зэвсэгтэй таван улсын (P5) байр суурь, баталгааны хэлбэр, агуулгын талаар явагдсан олон талт зөвлөлдөх үйл явцыг цогцоор нь авч үзэв. Түүнчлэн Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний дэмжлэг, өрнөдийн P3-ын хамтарсан демарш, гурван этгээдийн Женевийн зөвлөлдөх уулзалт, Монгол–P3-ын зөвлөлдөх механизм зэрэг дипломат хүчин чармайлтын үр дүнг үнэлж, Монгол Улсын санаачилгын бодит хэрэгжилтийн нөхцөл, тулгарсан сорилтуудыг тодорхойлов.

Судалгааны үр дүнд Монгол Улсын нэг улсын цөмийн зэвсгээс ангид статус нь уламжлалт бүсчилсэн ЦЗБ-ийн үзэл баримтлалыг нөхөн баяжуулж, газарзүй, геополитикийн онцлог нөхцөлд цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх дэглэмийг бэхжүүлэх шинэ эрх зүйн болон улс төрийн боломжийг бүрдүүлснийг харуулав. Мөн ЦЗБ-ийн өнөөгийн бүтцийн зарим доголдлыг даван туулахад ийм төрлийн уян хатан загвар нь бодитой шийдэл болж болохыг дүгнэж, Монгол Улсын туршилага нь олон улсын аюулгүй байдал, үл дэлгэрүүлэх тогтолцоог боловсронгуй болгож, ЦЗБ-ийн тогтолцооны доголдлыг арилгаснаараа онол, практикийн ач холбогдолтой болсон.

Түлхүүр үгс: Монгол Улс; цөмийн зэвсгээс ангид статус; цөмийн зэвсэггүй бүс; НҮБ; P5; цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх; аюулгүй байдлын баталгаа; олон улсын эрх зүй

Түүхэн хэсэг

Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид статус (ЦЗАС)-ын асуудал нь хүйтэн дайны үе дуусгавар болоход гарч ирсэн. БНМАУ нь хүйтэн дайны үед Зөвлөлт Холбоот Улс (ЗХУ)-ын холбоотон байхдаа 1966 онд хоёр орны найрамдал, хамтын ажиллагаа ба харилцан туслах гэрээг шинэчлэн байгуулж, улмаар ЗХУ БНМАУ-ыг Хятадын аюулаас хамгаалах нэрээр цэргийн баазуудаа 1967 онд Улаанбаатарын дөрвөн дүүрэг, 15 аймагт байрлуулах болсон нь үнэн хэрэгтээ Зөвлөлт-Хятадын үзэл суртал, нутаг дэвсгэр, хил хязгаарын маргаанаас үүдэн байрлуулсан байдаг (МУИС, 2016).

Хоёр хөршийн хилийн зөрчилдөөн 1969 онд эрс хурцадсанаар хоёр улсын хилийн нэн ялангуяа зүүн хэсэгт гуравдугаар сард том мөргөлдөөн гарч, хоёр талаас мянга гаруй цэрэг амь үрэгдсэн байдаг. ЗХУ, БНХАУ-ын нэн ялангуяа цөмийн зэвсэг болон байгууламжийн эсрэг, түүнээс хэрхэн урьдчилан сэргийлж болох арга хэмжээний тухай саналаа илэрхийлж, Варшавын гэрээний байгууллагын холбоотнууддаа мэдэгдэж байсны дээр хоёр дахь хэт их гүрэн болох АНУ-ын байр суурийг тандсан байдаг. Тэгвэл Хятад, Зөвлөлтийн гэнэтийн довтолгооноос сэргийлэх үүднээс зэвсэгт хүчнээ бэхжүүлж, агаарын довтолгооноос ард иргэдээ хамгаалах зорилгоор тунель ухаж, орогнох байр барих, хил орчмын мужуудад дайчилгаа зарлан цэргийн хээрийн сургуулилтыг үе үе хийж буй талаар Хятадын болон олон улсын хэвлэлд цаг үеийн мэдээ, мэдээллийг цацаж байв.

Америк коммунист хоёр гүрний өрсөлдөөний хүч багатай талд орж, тэдний хүчин зүйл, жин нөлөөг Зөвлөлтийн эсрэг дэнслүүлэн ашиглахыг зорьж байв. Иймээс Зөвлөлтийн саналыг нь дэмжихгүй гэдгээ мэдэгдэж, хэрэв Зөвлөлт Хятадын эсрэг хүч хэрэглэвэл үүнийг дэлхийн III дайныг өдөөсөн үйлдэл гэж үзэн зохих хариу арга хэмжээ авах байр сууриа илэрхийлсэн.

Хятадын цөмийн зэвсэг туршихаар бэлтгэж байсныг харгалзан Америк 1964 онд Зөвлөлтөд хандан Хятадыг цөмийн туршилт явуулахаас нь өмнө урьдчилан сэргийлэх хамтарсан цохилт өгөх санал дэвшүүлсэн боловч Зөвлөлтийн тал уг саналыг хүлээн аваагүй. Энэхүү байр суурь нь 1969 онд Зөвлөлтийн тандалтад өгсөн хариуг харгалзсан байж болзошгүй. Хэрэв ЗХУ энэ туршилтад оролцсон бол Зөвлөлтийн цэргийн баазуудыг нутагтаа байрлуулж байсан БНМАУ уг мөргөлдөөнд шууд татагдан орж, хамгийн түрүүнд цэргийн цохилтод өртөх өндөр эрсдэлтэй байв. Үүнийг тухай үеийн АНУ-ын Агаарын стратегийн командлал (Strategic Air Command)-ын эх сурвалжуудын мэдээлэл бататгадаг. Тэдгээрийн мэдээлснээр Зөвлөлтийн цөмийн хоёр пуужин Монголын нутаг дэвсгэрт байрлаж байсан тул Америк тэдгээр баазыг цөмийн цохилтын бай болгон онилсон байжээ. Энэ талаар АНУ-ын холбогдох албан тушаалтнууд хожим нь дурдсан байдаг.

Цөмийн зэвсэггүй бүс байгуулах явц

Цөмийн зэвсэг 1945 онд буй болсон цагаас хойш тэрхүү зэвсгийг олон улсын хатуу хяналтад авах, хориглох, устгах, улмаар цөмийн зэвсэггүй бүс (ЦЗБ) байгуулах 15 орчим санал санаачилга гарснаар өнөөдрийн байдлаар таван бүс¹ байгуулагдсан бол харин Умард болон Төв Европ, Балканы хойг, Газрын дундад тэнгис, Өмнөд Ази зэрэгт цөмийн зэвсэгтэй зарим улсын улс төр, геополитикийн ашиг сонирхолд үл нийцэж байсан тул дэмжигдэж хэрэгжээгүй байна.

Хүйтэн дайны үед “энх тайвны бүс” дангаараа байгуулах талаар санал санаачилга гарч байв. Тухайлбал: Балбын хаан Бирендра 1975 онд Балбыг “энх тайвны бүс” болгох замаар Энэтхэгийн нөлөөг багасгах, улмаар Энэтхэг, Хятадтай арай тэнцвэртэй бодлого баримтлах бодолтой байв. Балбачууд тэрхүү саналаа нэлээд олон жил идэвхтэй зүтгүүлж, НҮБ-ын гишүүн 100 гаруй улсын болон ялангуяа АНУ, БНХАУ-ын дэмжлэгийг авч чадсан хэдий ч ЗХУ-ын дэмжлэг бүхий БНЭУ-ын байр сууринаас болж санаачилга нь талаар болсон байдаг.

Цейлон (одоогийн Шри Ланка) Энэтхэгийн далай дахь Английн сүүлчийн колони устсаны дараахан тэрхүү далайг “энх тайвны бүс” болгох саналыг 1971 онд дэвшүүлсэн. Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн (ЭҮНХ)-ий орнуудын дэмжлэгтэйгээр НҮБ-ын Ерөнхий Ассамблей уг асуудлаар санал хурааж “Энэтхэгийн далайг энх тайвны бүс” хэмээн тунхаглаж, 1972 оноос түүнийг хэрэгжүүлэх зорилгоор 15 улсын бүрэлдэхүүнтэй Түр хороо байгуулан ажиллуулсан. Түүнээс хойш хагас зуу гаруй жил өнгөрч, хорооны бүрэлдэхүүн 44 болон өргөжиж, нийт 460 гаруй удаа хуралдаж ирсэн боловч тунхаглалын зорилго, зорилт хэрэгжээгүй, гагцхүү цаасан дээр тэмдэглээстэй байсаар байна. Учир нь Өрнөдийн гүрнүүд Энэтхэгийн далайд чөлөөтэй зорчиж, Ойрх Дорнодоос газрын тосны худалдаа, түүний эргэлтэд хяналт тавих, цаашлаад цэргийн бааз байгуулах сонирхолтой холбоотой байсан, одоо бүр ч лавширч байгаа. Өөрөөр хэлбэл: хэдийгээр олонхын саналыг авсан ч стратегийн чанартай аливаа санал санаачилга нь их гүрнүүдийн дэмжлэггүй бол бараг хэрэгждэггүй хоосон мөрөөдөл болж үлддэг байлаа. Тиймээс санал санаачилгыг урагшлуулан хэрэгжүүлэхэд их гүрнүүдийн дэмжлэг даяарчлагдаж байгаа өнөө үед ч чухал хэвээр байна.

Өнөөдрийн байдлаар 116 улс буюу НҮБ-ын гишүүдийн 60 орчим хувь нь таван ЦЗБ байгуулж, түүнд дэлхийн хуурай газрын 84 сая км²-ийн талбай хамрагдаж, энэ бүсэд хүн амын 39 орчим нь аж төрж байна. Тэгвэл одоогоор яригдаж байгаа Ойрх Дорнодод, мөн Зүүн Хойд Ази болон Хойд мөсөн далайд ЦЗБ нэмж байгуулбал Р5-аас цөмийн зэвсгийн талаар явуулах үйл ажиллагааны цар хүрээ тэр хэмжээгээр хумигдаж, олон улсын энх тайван, тогтвортой байдалд эергээр нөлөөлнө.

НҮБ-ын ач холбогдол

НҮБ-ын Ерөнхий Ассамблей олон улсын харилцааны чухал тавцан болдог учраас улс орнууд, нэн ялангуяа жижиг улс орнууд түүнийг гадаад бодлогын

¹ Латин Америк, Карибын бүсэд, Номход далайн өмнөд хэсэгт, Зүүн өмнөд Азид, Африк тивд болон Төв Азид.

зорилтоо зарлан мэдэгдэж, хэрэгжүүлэх чухал суваг гэж үздэг. Тиймээс ч олонх нь санал санаачилгаа Ерөнхий Ассамблейн чуулганд гаргаж, тэдгээрийн бараг 90 хувь нь хурлын протоколд тусгагдсанаар НҮБ-ын архивт шилждэг. Арав орчим хувийн бараг хагас нь хоёр дахь жилийнхээ нүүрийг үзэж аажимдаа мартагддаг бол үлдсэн 3-5 хувь нь бие даан асуудал болох буюу төстэй асуудалд тусгагдан тодорхой хэмжээгээр хэрэгждэг. Олон улсын харилцааны хурцадмал байдал нэмэгдэж, цөмийн зэвсэг тоо, хэмжээ, чанар тасралтгүй өсөх хандлагатай байгаа энэ үед цөмийн зэвсэггүй улсууд хамтын ажиллагаагаа эрчимжүүлэн, цөмийн зэвсгийг хориглох үйл ажиллагааг уялдуулан хэрэгжүүлсний үр дүнд цөмийн зэвсгийг хориглох тухай олон этгээдийн гэрээг 2017 онд байгуулсан. Уг гэрээнд одоогоор 95 улс гарын үсгээ зурж, 74 улс соёрхон баталснаар гэрээний оролцогч улс болоод байна.

Нутаг дэвсгэрээ дангаараа ЦЗБ болгох 1992 оны Монголын санаачилгатай төстэй санаачилгыг өөр улс одоогоор гаргаагүй байгаа бөгөөд хөгжиж буй зарим улс, далайд гарцгүй Балба, Афганистан ихэд сонирхож байв. Монголын санаачилга хэр урагшлахыг харгалзаж, явцын талаар сонирхож, мэдээлэл авч байв. Монголын санаачилга дээр дурдсан 90 хувийн санаачилгын тоонд орж болох магадлалтай ч баттай хэрэгжих баталгаа бага, хэрэгжих боломжгүй гэж үзэх үндэслэл ч алга байсан тул түүнийгээ зүтгүүлж, ажил хэрэг болгох бодлого зүй ёсоор тавигдаж байв.

Урьдчилан зөвлөлдөх эсэх асуудал

Монгол Улс P5-тай, нэн ялангуяа хөрш хоёр орон, АНУ-тай урьдчилж зөвлөлдөдөггүйгээр санаачилга гаргах нь эрсдэлтэй байлаа. Манай хоёр хөрш 1990-ээд оны эхээр харилцаагаа хэвийн болгохдоо гурав дахь улсын нутаг дэвсгэр, агаарын орон зайг бие биеийн эсрэг ашиглахгүй гэж тохирч тэр тухайгаа дэлхийд зарлан тунхаглаж байсан учраас манай улс бусад улсын адил түүнийг нь сайшаан дэмжиж байв². Тиймээс санаачилга гаргахдаа хоёр хөршийн саналыг авах шаардлагагүй гэж үзэж байв. Хэрэв тэдний саналыг асуусан бол маш чухал санаачилга байна гэхдээ цаг нь болоогүй гээд хариу өгөхгүй гэх газаргүй байсан.

АНУ-ын хувьд гэвэл Монгол нь ардчилал, чөлөөт зах зээлийн замаар замнах эхлэл тавигдаж байгаа болон бие даасан, хоёр хөршөөсөө ангид бодлого явуулж байгааг харгалзан улс төрийн хувьд дэмжихгүй байх аргагүй байв. Манай улс гишүүнээр нь шинээр элсээд удаагүй байсан Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн (ЭҮНХ) цөмийн зэвсгийн асуудлаар голдуу нэгдсэн байр суурьтай байдаг тул Монголын дэвшүүлсэн асуудал хөдөлгөөний нэгдсэн байр суурийг сулруулна гэсэн яриа ч гарч болох байлаа.

² ЗХУ, Хятад хоёр 1989 онд хамтарсан мэдэгдэл гаргахдаа “Хил залгаа гурав дахь орнуудын газар нутаг, гол мөрөн, нуур цөөрөм хийгээд агаар мандлыг ашиглах аргаар ч гэсэн бие биеийнхээ эсрэг хүч хэрэглэх буюу аль нэг хэлбэрээр мөчөөрхөхгүй, маргаантай бүх асуудлаа эв зүйгээр зохицуулна” гэж тохирч дэлхийд зарласан байдаг.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн шийдвэр

Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбат асуудлын эерэг, сөрөг талыг дэнсэлж үзээд зарим нэг асуудал гарсан ч харилцаанд сөргөөр нөлөөлөхгүй бол ЦЗБ байгуулах хандлага газар авч байгаа үед санаачилгаа зоригтой зүтгүүлээд үзэхийг дэмжиж, 1992 оны есдүгээр сарын 25-нд НҮБ-ын чуулганд үг хэлэхдээ улс оронд нь хийгдэж буй шинэчлэлийн талаар ярьж, улмаар “Монгол Улс зэвсэг хураах хийгээд бүс нутаг, дэлхий дахинд итгэлцлийг бэхжүүлэх үйлсэд хувь нэмрээ оруулах үүднээс өөрийн нутаг дэвсгэрийг “Цөмийн зэвсэггүй бүс” хэмээн зарлан тунхаглаж байна. Үүнийгээ цаашид олон улсын хэмжээнд баталгаажуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг эрмэлзэх болно” (United Nations General Assembly, 1992) гэж мэдэгдэв. Шууд эсэргүүцээгүй буюу эргэлзсэн улс гараагүй боловч асуудлыг цаашид хэлэлцэхэд эсэргүүцэх улс гарахыг үгүйсгэх аргагүй байв.

Монгол Улс 1993 онд ОХУ-тай, 1994 онд БНХАУ-тай найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээг тус тус байгуулсан. “Гадаадын цэрэг, цөмийн болон үй олноор хөнөөх бусад төрлийн зэвсгийг нутаг дэвсгэртээ байрлуулахгүй байх, нутаг дэвсгэрээрээ дамжуулан өнгөрүүлэхгүй байхад чиглэсэн Монгол Улсын бодлогыг Оросын Холбооны Улс хүндэтгэнэ” гэсэн заалт орсон нь асуудлыг урагшлуулахад нэмэр болох анхны алхам байв.

Санаачилгыг хэрэгжүүлэх бодит нөхцөл

Нэгэнт дэвшүүлсэн санаачилгаа ажил хэрэг болгох төлөвлөгөө гаргахад асуудлыг чухам юунаас эхлүүлэх, хэрхэн урагшлуулахаа тодорхой хэлж мэдэхгүй байв. Түүнийг урагшлуулахад хөгжиж байгаа улс орнууд эсэргүүцээгүй боловч аюулгүй байдлын баталгаа гаргуулж авах цөмийн зэвсэгтэй таван гүрний (товчоор P5-ын) байр суурь чухал байв.

Олон улсын харилцаанд аливаа санал санаачилгыг зайлшгүй шаардлагатай улс буюу бүлэг улсын дэмжлэгийг авснаар хэрэгжих боломжтой болдог. Тиймээс хөрш хоёр орноос гадна цөмийн зэвсэгтэй өрнөдийн гурван гүрэн (Америк, Англи, Франц буюу өрнөдийн P3)-ийн дэмжлэг чухал байв. Иймд Монгол дахь P5-ын Элчин сайдын яам (БНФУ ЭСЯ-аа хаагаад дахин нээгээгүй үе)-дад танилцуулж, дэмжихийг хүссэн. НҮБ-д олон улс санал санаачилга гаргадаг тул тэр болгоныг нь дэмжих боломж байдаггүй, асуудлыг бүх талаас нь нарийн судлах хэрэгтэй гэсэн ерөнхий хариу өгч нэг ёсондоо хамтарч ажиллах онцын сонирхолгүй байгаа сэтгэгдэл төрүүлж байв.

Орос, Хятадын дипломатуудтай ярилцахад нэгэнт нэг туйлт ертөнц буй болж байгаа тул Америктай шууд ярихыг зөвлөж, асуудлыг өөрсдөөсөө зайлуулах хандлагатай байв. Харин АНУ-ын ЭСЯ тэр үед Монгол Улсад олгох буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлийн талаар ихэвчлэн ярьж ажилладаг байв.

Үл дэлгэрүүлэх гэрээний хүчин зүйл

Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх тухай гэрээ (цаашид Үл дэлгэрүүлэх гэрээ гэж товчлов)-ний үйлчлэх хугацаа дуусгавар болж, гэрээг хэрхэн сунгах талаар 1995 онд яригдаж эхлэв. АНУ-ын Элчин сайд Монгол Улсын талд хандаж, гэрээг тодорхой бус хугацаагаар дэмжихийг хүсэхэд манай тал зөрүүлээд өөрийн санаачилгыг сануулж, харилцан дэмжихийг санал болгов.

АНУ-ын Элчин сайд тухайн үед шууд хариу өгч чадахгүйгээ мэдэгдээд Төрийн департаменттайгаа зөвлөлдөөд хариу өгөхөөр болов. Удалгүй гэрээний хугацааг тодорхой бус хугацаагаар сунгахыг дэмжвэл Америк Монголын саналын талаар зэрэг мэдээ хэвлэлдээ тавьж болно гэсэн хариу өгөв. Энэхүү хариу нь Монгол Улсын хүлээлтийг бүрэн хангаагүй бөгөөд АНУ-ын тал “Дэмжсэн албан ёсны мэдэгдэл гаргавал уг санаачилгыг нааштайгаар авч үзэх боломжтой” гэсэн байр суурийг илэрхийлсэн юм. Үүний дараа хоёр сар орчим үргэлжилсэн албан бус зөвлөгөөний үр дүнд АНУ-ын Төрийн департамент Монгол Улс санаачилга гаргасан явдлыг 1993 оны 10 дугаар сард дэмжиж байгаагаа албан ёсоор мэдэгдэж “АНУ-аас цөмийн зэвсэггүй улс орнуудад мэдэгдлийн хэлбэрээр олгосон сөрөг аюулгүй байдлын баталгаа Монгол Улсад мөн адил үйлчилнэ. Хэрэв Монголд аюул занал учирч болох асуудлыг НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлд хандвал Зөвлөлийн бусад гишүүний хамт холбогдох арга хэмжээ авч хэлэлцэхэд оролцоно” хэмээн мэдэгдсэн (Монгол Улсын цөмийн зэвсэггүй статус, 2017).

Удалгүй АНУ-ыг дагаж цөмийн зэвсэгтэй бусад дөрвөн гүрэн дор бүрнээ Монголын санаачилгыг дэмжсэн мэдэгдэл гаргаснаар олон улсын хамтын нийгэмлэг манай санаачилга болон Р5-ын дэмжлэгийн талаар тодорхой мэдээлэлтэй болсон юм. Улмаар нэгдсэн мэдэгдэл гаргах тухай Монголын саналыг Америк, Орос, Хятад, Англи “Хэрэв бусад нь дэмжвэл тийм мэдэгдэл гаргахаас татгалзахгүй” гэж өөрсдөөсөө холдуулсан хариуг өгч байв. Харин Франц цөмийн зэвсгийн талаар баримтлах бодлогоо эргэн харж, ярьж болох талтай гэж Москвагаас хавсран суугаа Элчин сайд нь хэлж байв. Францын талын нэг болгоомжлол бол Франц францаар ярьдаг улсын бүлэг буюу франкофоны бүлгийн улсуудад баталгаа гаргаж өгөөгүй мөртөө алс холын Монголд гаргахыг ойлгохгүй гэж тайлбарлаж байв. Нэгдсэн мэдэгдэл гаргах тухай Элчин сайдад сануулахад “Тэр чинь яваандаа баталгаа болж хувирахгүй гэх газаргүй шүү дээ” гэж хэлээд инээж байв. Хэдэн сар хүлээлгэсний эцэст Францын тал хамтарсан мэдэгдэл гаргахыг дэмжихгүй гэсэн хариу өгснөөр уг асуудал мухардалд орсон.

Асуудлыг Ерөнхий Ассамблейн хурлаар хэлэлцүүлэх шаардлага

Монголын тал асуудлыг дангаараа ажиллан Р5-ын дэмжлэгийг авах боломжгүйгээ мэдэрч, асуудлыг өргөн хүрээнд түүний дотор ЭУНХ, цаашилбал, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн хэмжээнд тавьснаар Р5-ын дэмжлэгийг авч урагшлуулахаар шийдсэн. Зарим улс “Өөрт нь шууд аюул занал учраагүй байхад ийм

асуудлыг зэвсэг хураах, олон улсын аюулгүй байдлын асуудал болгон хэлэлцүүлж байгааг ойлгохгүй байна” гэсэн яриа гаргаж байсныг 1969 оны үйл явдал, Монгол Улс ямар нэгэн улс төр-цэргийн байгууллагад нэгдээгүй, аливаа их гүрэнтэй холбоотны харилцаа тогтоогоогүй зэргийг учирлахад илт эсэргүүцэх улс гараагүй. Тийм яриаг P5-ын аль нэг нь гаргаагүй гэж хэлэх үндэсгүй байв.

P5-ын гол болгоомжлол

P5 хэдийгээр Монголын санаачилгын зорилго, явуулж буй бодлогыг сайтар ойлгож байсан ч “Нэг улс дангаараа ЦЗБ байгуулах нь зарим улс орныг уруу татаж, P5-ын геостратегийн бодлогод ашиггүй прецедент үүсгэж болох юм” гэж болгоомжилж байгааг АНУ-ын төлөөлөгч учирлан тайлбарлав. Монголын тал хариуд нь манай саналын дагуу P5 нэгдсэн нэг дорвитой мэдэгдэл гаргасан бол асуудлыг ингэж өргөжүүлэн хэлэлцэх шаардлага гарахгүй байсан гэж хариулж байв. P5 тэдний хувьд зарчмын чанартай гэж үзсэн энэхүү асуудлыг болж өгвөл НҮБ-д өргөнөөр хэлэлцүүлэхгүй, цаашид газар авхуулахгүй байх буюу институтчилэхгүй (not institutionalize) байлгах сонирхолтой. Монгол Улс уг асуудлаар ажлын баримт бичиг боловсруулж³ Ерөнхий Ассамблейн салбар байгууллага болох Зэвсэг хураах комиссоор хэлэлцүүлэх гэхэд тэд тун дурамжхан байв.

Тиймээс нэг улс дангаараа ЦЗБ байгуулах санааг Ерөнхий Ассамблейн комиссоос ЦЗБ цаашид хэрхэн байгуулж байх асуудлаар гаргасан 1999 оны “зааварчилга”-д огт тусгахгүй байх талаар P5 комиссын удирдлагатай хэлэлцэж санасандаа хүрсэн. Монголын талын хийж чадсан ганц зүйл нь 1998 онд уг асуудлаар Ерөнхий Ассамблей тогтоол батлан гаргасан тухай мэдээллийг комиссын 1999 оны илтгэлд товч тэмдэглүүлсэн явдал байв. Нэгэнт асуудлыг Зэвсэг хураах комиссоор нухацтай хэлэлцээгүй учраас бүх гишүүн идэвхтэй оролцдог Ассамблейн I хорооны бүгд хуралдаанд Монгол асуудлаа шууд тавьж, хэлэлцүүлэн олон улсын анхаарлыг хандуулах замаар P5-тай шууд яриа хэлэлцээ хийх арга замыг сонгосон юм.

Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний бодлого

Үл дэлгэрүүлэх гэрээний 1995 онд болсон бага хурлаас тус гэрээг санал хураалт явуулалгүйгээр тодорхой бус хугацаагаар сунгаснаар P5 гол зорилгодоо хүрч, цаашид Монгол болон цөмийн зэвсэггүй орнуудын дэмжлэг тэдэнд хэрэггүй болсон нь тэдний хандлагаас ажиглагдав. Харин ЭҮНХ дэмжиж, 1995 оны дээд хэмжээний Картагенийн хурлаас Монголын санаачилгыг “Бүс нутгийн тогтвортой байдал, итгэлцлийг бэхжүүлэхэд эерэг хувь нэмэр оруулж байна” гэсэн мэдэгдэл гаргасан нь олон улсын хэмжээнд дэмжсэн анхны чухал алхам болсон.

Монголын төлөөлөгчид санаачилгынхаа талаар НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас тогтоол гаргуулахаар P5-ыг төлөөлсөн АНУ-ын төлөөлөгчтэй ярилцаж, тогтоолын төсөлд тусгаж болох гол санаагаа 1997 онд танилцуулав. Тэр үед ЭҮНХ-ний сайд

³ A/CN/10/195 of 22 April 1997

нарын Делийн хурлаас “Сайд нар өөрийн статусыг ЦЗБ болгох талаар Монголоос гаргаж буй хүчин чармайлтыг сайшаан дэмжиж байна” гэсэн мэдэгдэл хийснээр тус улсын байр суурь олон улсын хэмжээнд харьцангуй бэхжив. Харин ЭҮНХ-ний зүүн жигүүрийнхэн Монгол дангаараа ЦЗБ байгуулах санаачилга гаргасныг дэмжихгүй байх ямар ч үндэсгүй тул Ерөнхий Ассамблейд хэлэлцүүлэн ардчилсан зарчмын дагуу тогтоолоор санал хураалгаж уг асуудлыг шийдвэрлэх талаар өөр хоорондоо зөвлөлдөж тохирвол хөдөлгөөний дийлэнх нь дэмжинэ гэж Монголын талыг зоригжуулж байлаа.

Өрнөдийн P3-ын хамтарсан демарш

Америкийн тал P5-ыг төлөөлөн Монголын талтай хийсэн уулзалтын үеэр Монгол Улсыг ЦЗБ гэж хүлээн зөвшөөрөхгүй гэдгээ илэрхийлсэн. Үүний зэрэгцээ өрнөдийн P3 орон Улаанбаатар, Нью-Йорк, Женев хотод нэгэн зэрэг хамтарсан демарш хүргүүлж, хэрэв Монгол Улс тогтоолын төслөө 1997 оны НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганаар хэлэлцүүлбэл уг асуудал нь “Цаг үеэ олоогүй, асуудлыг шийдвэрлэхэд тус болохын оронд саад учруулж, Монголын хүлээж буйгаас эсрэг үр дүнд хүргэж болзошгүй”⁴ хэмээн анхааруулсан байна. Иймд тогтоолын төслийг хэлэлцүүлэх асуудлыг нэг жилээр хойшлуулж, энэ хугацаанд асуудлыг илүү дэлгэрэнгүй зөвшилцөн ярилцах санал дэвшүүлжээ.

Монголын тал Цейлоны (Шри Ланкийн) 1972 оны гашуун туршлагыг бодолцон асуудлыг санал хураалгах замаар биш, харин эв зүйгээр урагшлуулах бодлого баримтлав. P3-аас хамтарсан демарш хийснийг ашиглан Монголын тал аюулгүй байдлын баталгаа нь эрх зүйн үндэстэй байхгүй бол цаашид P5 хамтран буюу 2-3 нь, тэр ч байтугай аль нэг нь ганцаарчлан сүрдүүлсэн мэдэгдэл хийж, дарамт шахалт үзүүлэхгүй гэх газаргүйг анхааруулж, Монголын хувьд эрхзүйн үндэстэй баталгаа зарчмын ач холбогдолтойг тэдний хийсэн демаршийг ашиглан ярьж, Монголын үндсэн зорилгыг дахин тайлбарлав. АНУ-ын төлөөлөгчөөс Орос, Хятадын байр суурийг сонирхоход тэд тийм демарш хийж байгааг мэдэж байгаа, харин Монголын хөршийнхөө хувьд оролцоход эвгүй мэт үзэж демаршд оролцохгүй гэж тэд шийдвэрлэснээ мэдэгдсэн гэв.

Ерөнхий Ассамблейн тогтоолын төсөл

Монголын тал P5-тай харилцаагаа хурцатгах бодолгүй, давын өмнө Ерөнхий Ассамблейгаар санаачилгыг дэмжсэн тогтоол батлуулах сонирхолтой байсан тул асуудлыг нэг жилээр хойшлуулах тэдний саналыг хүлээн авч агуулгынх нь талаар АНУ болон P5-ын бусад гишүүдтэй хэдэн сар албан бусаар зөвлөлдөв. Яриа хэлэлцээний үеэр P5 нэг улс дангаараа ЦЗБ байж болох талаарх Монголын саналыг хүлээн зөвшөөрөх боломжгүйгээ илэрхийлснээс гадна уг асуудлыг албан ёсоор хэлэлцэж дэмжсэн олон улсын ямар нэгэн механизм байгуулах буюу

⁴ “premature, unhelpful, counter-productive”. Өрнөдийн P3 тэрхүү демаршийг аминчилж хийсэн тул түүнийг Монгол Улсын Цөмийн Зэвсгээс Ангид Статусын холбогдолтой баримт бичгүүдэд тусгаагүй.

институтчилэхийг дэмжихгүй гэдгээ мэдэгдэв. Тиймээс тэд тогтоолын агуулгын талаар ярихаасаа өмнө “бүс” гэдэг ойлголтоос татгалзах хэрэгтэй гэж шахав. P5 тэрхүү санаагаа өөрсдөө илэрхийлж байснаас гадна тэр үеийн Европын Эдийн Засгийн Хамтын Нийгэмлэг (өөрөөр хэлбэл: одоогийн Европын Холбоо)-ийн төлөөлөгчөөр дамжуулан Монголын талд тавьж, “бүс” хэмээх ойлголтын оронд арай бүрхэг ухагдахуун болох “статус”-аар солихыг санал болгож байв. Монголын тал түүнийг нь сөргүүлээд бүлэг улсыг бодвол нэг улс аюулгүй байдлаа дангаараа хамгаалахад хавьгүй хэцүү байдгийг тайлбарлаж, Монгол Улсын гадаад аюулгүй байдлыг бэхжүүлэхийг дэмжсэн заалт болгон тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хил хязгаарын халдашгүй дархан байдал, эдийн засгийн аюулгүй байдал, экологийн тэнцвэрт байдал, бие даасан гадаад бодлогыг дэмжсэн заалтуудыг тогтоолд тусгаж оруулах санал болгосныг P5 зөвлөлдөж зөвшөөрсөн. P5-аас Монголд олгох аюулгүй байдлын баталгааны агуулга, хэлбэрийн талаар ярилцахад Монголтой санал үлэмж зөрүүтэй байсан тул түүнийг анхны тогтоол батлагдсаны дараа, аажуу тайван, олон талаас нь ярилцаж шийдвэрлэхээр тохиров. P5 статусыг ямар нэгэн байдлаар институтчилэхийн эсрэг байгаагаа дахин мэдэгдэж байсан тул тогтоолын заалтуудыг хэрэгжүүлэхэд НҮБ-ын холбогдох байгууллагууд өөр өөрсдийн шугамаар улс төрийн дэмжлэг үзүүлэхээ АНУ P5-ын өмнөөс мэдэгдэв. Хэрэв зарим тодорхой арга хэмжээ авахад зардал гаргах шаардлага гарвал түүнийг НҮБ-ын төсвөөс гаргуулахыг санал болгоход P5 хоорондоо ярилцаад зөвшөөрөв.

Тогтоолыг нэг эсвэл олон удаагийнх болгох уу гэж нэлээд ярилцаад асуудлыг бүрэн шийдтэл хэрэгжилтийнх нь талаар НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга (ЕНБД)-ын илтгэлийг Ерөнхий Ассамблейгаар хоёр жил тутам хэлэлцэж байхаар тогтов. Тогтоолын төслийг эцэслэн Нарийн бичгийн дарга нарын газар (НБДГ)-т хэвлүүлэхээр ажиллаж байхад Франц, Хятадын төлөөлөгчид 10-аад засвар, өөрчлөлт оруулахыг санал болгосныг Монголын тал хүлээж авалгүй үндсэн тохиролцоогоо хадгалж, Монгол Улс тогтоолын санаачлагч болж асуудлыг танилцуулж батлуулахаар болсон.

Асуудлыг хорооны хэмжээнд хэлэлцэх үеэр Филиппин хөгжиж байгаа орнуудыг төлөөлөн манайд улс төрийн дэмжлэг үзүүлэх үүднээс тогтоолд хамтран зохиогчоор оров. Тогтоолыг санал хураалгүйгээр 53/77 D тоот тогтоол болгож батлав (Монгол Улсын цөмийн зэвсэггүй статус, 2017).

Тогтоолын ач холбогдол

Монгол Улсын олон улсын (өөрөөр хэлбэл: манай гадаад аюулгүй байдлын) статусыг үндэсний аюулгүй байдлаа хангах нэг арга хэрэгсэл мөн болохыг нотолж, хөрш хоёр оронтойгоо сайн хөршийн тэнцвэртэй харилцааг хөгжүүлж байгаа нь өөрийн төдийгүй бүс нутгийн энх тайван, аюулгүй тогтвортой байдлыг бэхжүүлэх нэг чухал хүчин зүйл болсныг тогтоол сайшаан дэмжив. Олон улсын хамтын нийгэмлэг тус улсын аюулгүй байдлыг бүс нутгийн аюулгүй байдалтай шууд холбосноороо ач холбогдолтой болов. Мөн тогтоолын агуулга Монгол Улс цөмийн

зэвсгээс ангид статус (ЦЗАС)-аа тунхаглан зарласныг сайшаан хүлээн авч, цаашид урагшлуулах улс төрийн үндсийг нь тавив.

Тогтоолын гарчиг болон түүний агуулгад Монгол Улсын олон улсын аюулгүй байдлыг дурдсан нь тус улсын гадаад аюулгүй байдлыг шууд хөндөж, манай улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тусгагдсан гадаад үндсэн чиглэлүүдийг дурдаж, тэдгээр чиглэлээр Монгол Улстай хамтарч ажиллахыг нийт гишүүн орнуудад, түүний дотор Р5-д уриалсан.⁵

Тогтоолыг хэрэгжүүлэхэд нарийн ажиллагаа хэрэгтэй

НҮБ-ын Ерөнхий Ассамблей болон олон улсын бусад байгууллага олон тооны тогтоол шийдвэр гаргадаг. Тэдгээр нь асуудлыг шийдвэрлэх талаар зарчмын тохиролцоо, ойлголтыг тусгасан байдаг нь чухал ач холбогдолтой. Харин тохирсныг хэрхэн хэрэгжүүлэх асуудалд нарийн мэдрэмж, ажиллагаа шаардагддаг. Нэн ялангуяа тохирсноо хэрхэн ямар дэс дарааллаар хэн хэрэгжүүлэх, санхүүгийн зардал гарвал түүнийг хаанаас ямар нөхцөлөөр гаргах зэрэг асуудал гардаг. Ерөнхий Ассамблейгаар батлагдсан уг тогтоолыг хэрхэн хэрэгжүүлэх талаар Монгол болон Р5-ын хооронд санал нэлээд зөрөв. Тогтоолыг хэрэгжүүлэхэд хамтын төлөвлөгөө гаргаж ажиллах саналыг Монголын тал тавихад Р5 аажимдаа эрх зүйн үндэстэй баримт бичиг болж хувирч болзошгүй гэж үзэн хүлээж аваагүй. Монгол Улс НҮБ-ын төрөл бүрийн салбар, нэгжийг ашиглаж өөрийн бодлогыг явуулах гэж оролдох тул түүнд НҮБ-ын төсвөөс хөрөнгө дэмжлэг гаргуулах боломжийг хаах арга хэмжээ авах санаа Р5-д тэр үед байсан. Тиймээс тэд анх батлагдсан тогтоолд “НҮБ-ын тухайн нөөц бололцооны хүрээнд Монгол Улсад шаардлагатай тусламж үзүүлэх талаар зохих арга хэмжээ авахыг ЕНБД болон НҮБ-ын холбогдох байгууллагуудаас хүсэж байна” гэсэн заалтыг шахаж оруулсан. Тэрхүү заалт нь НҮБ-ын тогтоолыг хэрэгжүүлэхэд хөрөнгө гаргах аливаа тодорхой арга хэмжээг тусгаж хэрэгжүүлэхэд хүндрэл учруулдаг. Иймд 2000 оны тогтоолын төслийг хэлэлцэхийн өмнө, хэрэв Р5-ийн орнуудыг нэр заасан нэмэлт заалтыг тогтоолд тусгах сонирхолгүй бол санхүүгийн үр дагавартай холбоотой заалтыг тогтоолын төслөөс хасах санал дэвшүүлэв. Үүний дагуу Р5-ийн төлөөлөгчид хоорондоо зөвшилцөж, уг заалтыг тогтоолд оруулахгүй байхаар тохиролцсон.

Монгол Улсын эдийн засаг, байгаль орчны аюулгүй байдлын асуудлаар НҮБ-ын холбогдох байгууллагын мэргэжилтнүүдийн оролцоотой тусгай судалгаа боловсруулах саналыг Монголын талаас дэвшүүлж, НҮБ-ын Нарийн бичгийн даргын газар уг саналыг дэмжин хоёр судалгааг боловсруулсан. Үүний үр дүнд 2004 онд баталсан манай асуудлаарх тогтоолд эдгээр судалгааг боловсруулсанд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад талархал илэрхийлсэн тусгай заалтыг тусгасан. Ийнхүү Монгол Улс НҮБ-ын байгууллагын чадавх, боломжийг үр ашигтай ашиглан тогтоолын хэрэгжилтийг бодитой дэмжих нөхцөлийг бүрдүүлж чадсан.

⁵ 1998 оны Ерөнхий Ассамблейн 53/77 D тоот тогтоолын 3 дугаар заалт.

Энэ хугацаанд ОХУ болон бусад улстай хамтран Монгол Улсад зохих аюулгүй байдлын баталгаа олгох боломжтой талаар НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганы үеэр мэдэгдсэн юм. Үүний дараа Р5-тай хийсэн уулзалтын үеэр Монголын тал Оросын төлөөлөгчөөс уг саналын агуулгыг тодруулахад тэрээр Монгол Улстай олон улсын гэрээ байгуулах боломжтой хэмээн тайлбарлаж эхэлсэн бөгөөд Хятадын төлөөлөгч уг байр суурийг дэмжиж буйгаа толгой дохин илэрхийлжээ. Харин Америкийн тал олон улсын гэрээ байгуулахыг дэмжихгүй гэдгээ дахин тодорхой мэдэгдэж, Англи, Францын төлөөлөгчид эн байр суурийг дэмжсэнээр уг санал цааш хэрэгжих боломжгүй болсон.

Монголын тал санаачилгыг алдахгүйн тулд 1999 онд ЦЗАС-ын талаар үндэснийхээ хэмжээнд гаргах хуулийн төслийг УИХ-аар хэлэлцүүлж байхад өрнөдийн Р3 түүний агуулгын талаар шаргуу сонирхож, 2000 оны хоёрдугаар сард хууль батлагдсаны дараа тэр талаар асууж тодруулахаа болив. Хуулийг яагаад гэнэт сонирхохоо больсныг асуухад хууль нэгэнт батлагдсан тул танай дотоод хэрэгт оролцолтой нь биш дээ гэж байв. “Та нар зарим улсын хуулийг, нэн ялангуяа хүний эрхийн холбогдолтой хуулийг шүүмжилдэг биз дээ” гэхэд “Тэр бол манай бодлого юм” гэж инээмсэглэн хариулж байв. Ямартай ч Р5 Монгол Улс хууль гаргасны хариуд түүнд олгох баталгааны талаар эхлээд өөр хоорондоо, дараа нь Монголтой зөвлөлдөв.

Баталгааны агуулга, хэлбэр

Монголын тал ЦЗБ байгуулах талаар Ерөнхий Ассамблейгаас 1975 онд баталсан 3472 (XXX) тогтоолд туссан олон талт гэрээ байгуулах замаар ЦЗБ байгуулах заалтад түшиглэн 3+3 хувилбарын нөхцөлөөр гэрээ байгуулахыг Р5-д санал болгов. Өөрөөр хэлбэл: Монголын тал Орос, Хятадтай хамт цөмийн зэвсгээс ангид байх тус улсын статусыг тодорхойлон эрх зүйн үндэстэй баталгаа гаргуулж авах, тэр хоёрын баталгааг сайшаан дэмжсэн өрнөдийн Р3-ын протоколыг нэмж оруулахыг санал болгов. Тийм гэрээнд өрнөдийн Р3 оролцох ямар хэрэг байгааг тэд асуухад нь цөмийн баталгааны асуудлаар Р5 хамтдаа баталгаа гаргадгийг харгалзсан, зөвхөн гурван этгээдийн гэрээ байгуулснаар Монгол энэ асуудлаар нөгөө хоёрынхоо нөлөөнд бүрэн орох болзошгүй учир түүнээс тодорхой хэмжээгээр сэрэмжлэхийн тулд condominium буюу хамтран ноёрхох буюу захирахаас болгоомжилж гуравдагч нөлөө бүхий хөршүүдийг татаж оролцуулах зорилготой юм гэж Р3-т тайлбарлав. Р5 Монголын 3+3-ын хувилбарыг ЦЗБ байгуулах үзэл баримтлалд бүрэн нийцэхгүй гэж үзэж байгаагаа мэдэгдэж 3+3 хувилбарыг дэмжихээс зайлсхийв.⁶ Оронд нь тэд Монголын саналыг дэмжиж 3 үе шаттай арга хэмжээ авах санааг илэрхийлэв. Өөрөөр хэлбэл: 1998 онд Монголын асуудлаар гурван талт гэрээ байгуулахыг дэмжсэн тогтоол батлах, 1999 онд гурван талт гэрээ байгуулах, 2000 онд гурван талт гэрээ байгуулсныг сайшаасан тогтоол гаргаснаар асуудлыг бүрэн шийдвэрлэж хаах санаа агуулж байв. Монголын тал

⁶ UNGA resolution 3472 (XXX) B of 11 December 1975

зарчмын хувьд дэмжиж⁷ гурван этгээдийн дан ганц гэрээ байгуулахын оронд 3+3-ын томьёо бүхий саналаа дахин тавихад өрнөдийн РЗ дурамжхан байж яриа хэлэлцээний үеэр түүнийгээ гурван үе шаттай саналаа татан авч оронд нь дараах дөрвөн зүйлийг санал болгов. Нэгд, Монголыг байнгын төвийг сахисан улс хэмээн зарласан тогтоолыг Ерөнхий Ассамблейгаар батлан гаргах; хоёрт, Монголын эргэн тойрныг сайн хөршийн харилцаа хөгжүүлэх бүс болгохыг Ерөнхий Ассамблейгаас олон улсын хамтын нийгэмлэгт уриалах; гуравт, Монгол-Орос, Монгол-Хятад хилийн аюулгүй байдлын гэрээг тус тус байгуулж, Монгол Улсын хил орчмын аюулгүй байдлыг хангахад дөхөм үзүүлэх; дөрөвт, ОХУ-ын адил БНХАУ-аас Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид байх бодлогыг хүндэтгэх заалт бүхий гэрээг Монгол-Хятадын хооронд байгуулахыг дэмжих. ОХУ, БНХАУ хоёр өрнөдийн гүрнүүдийн эдгээр саналын талаар мэдэж байсан бөгөөд тийм саналыг Монгол Улсын талд тавиад үзэхэд татгалзаагүй гэдгээ тэдэнд мэдэгдсэн байв.

Тэдгээр санал нь өнгөцхөн харахад чухал мэт санагдах боловч угтаа Монголын санаачилгын чиглэл, агуулгыг өөрчлөх зорилготой байв. Тухайлбал: байнга төвийг сахих бодлогод баталгаа өгөх эсэхийг сонирхоход тэд “Баталгаа өгөхгүй” гэж хариулав. Тиймээс Монголын тал дөрвөн зүйлт санал гаргасанд нь РЗ-т талархал илэрхийлээд нутаг дэвсгэрээ цөмийн зэвсгээс ангид байлгаж, түүнийгээ Р5-аар баталгаажуулж, уг асуудлаар байнгын механизмтай болох (өөрөөр хэлбэл: институтчилэх) сонирхолтой байгаагаа сануулахад тэд дөрвөн зүйл бүхий саналаа цаашид хүчлээгүй орхисон. Р5-аас аюулгүй байдлын баталгаа гаргуулах бодлогынхоо хүрээнд Монголын тал Америк, Англи, Оросоос Украин, Беларусь, Казахстанд 1994 онд Будапештын меморандумаар олгосон баталгааны төстэй баталгааг олгохыг Америкт санал болгов. Тэрхүү меморандум ёсоор Украин, Беларусь, Казахстанд Зөвлөлтийн үед тэдний нутаг дээр байрлуулж байсан цөмийн зэвсгээсээ тэд татгалзан Орост шилжүүлж, Үл дэлгэрүүлэх гэрээнд цөмийн зэвсэггүй улс болж нэгдэн орох, оронд нь Америк, Орос, Англи тэдний тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэж, дотоод хэрэгт нь үл оролцох, цөмийн болон ердийн зэвсгээр далайлгахгүй байх, эдийн засагт нь дарамт шахалт үзүүлэхгүй байхыг дээд хэмжээнд улс төрийн баталгаа болгон гаргаж өгсөн.

Тийм агуулга, хэлбэрийн баталгааг Монголд ч гаргаж өгч болох манай санааг Америкийн тал зарчмын хувьд нааштай хандаж байсан бөгөөд гол болгоомжлол нь эдийн засгийн баталгааны асуудал дээр Орос, Хятад хоёр эмзэглэж болзошгүй гэж байв. Далайд гарцгүй Монгол эдийн засгийн талаар аливаа дарамт шахалтад орохоос зайлсхийх тухай тайлбарлахад Америк байр сууриа өөрчилж, Будапештын меморандумыг нэгэнт ЕАБХАБ-ын шугамаар байгуулсан тул тэр нь Монгол, Хятад хоёрт огт хамаагүй гэж тайлбарлаж меморандумын төстэй баримт бичгийн талаар үргэлжлүүлэн ярилцахаа больсон. Удалгүй Р5 Монголд баталгаа олгох талаар өөрсдөө хамтарсан мэдэгдэл гаргахаа илэрхийлж, агуулгыг нь товч тайлбарлаж, зарчмын ямар нэгэн саналыг хүлээж авахгүй, харин үг үсгийн жижиг

⁷ Энэ асуудлыг Гадаад хэргийн сайдын зөвлөлөөр 1998 оны 7 сарын 3-нд хэлэлцээд зарчмын хувьд дэмжсэн.

сажиг саналыг харгалзаж болох юм гэж мэдэгдэв. Монголын зарчмын саналыг тусгаагүй мэдэгдэлд уг үсгийн засвар өөрчлөлт оруулж “сайжруулах” нь зарчмын болон агуулгын хувьд тохиромжгүйгээс гадна P5 түүнийг ашиглаж Монголтой нэгэнт тохирсон мэдэгдэл гаргасан хэмээн зарлаж асуудлыг хаахаас зайлсхийх үүднээс Монголын тал саналд нь ямар нэгэн санаа нэмэрлээгүй өнгөрөөсөн.

P5-ын хамтарсан мэдэгдэл, Монголын байр суурь

2000 оны чуулганы үеэр P5 Монголын статуст өгөх баталгааныхаа талаар хамтарсан мэдэгдэл хийж (Монгол Улсын цөмийн зэвсэггүй статус, 2017) Монголын тал түүнийг нь уг асуудлаарх яриа хэлэлцээг үргэлжлүүлэхэд чухал алхам болсон гэж албан ёсоор мэдэгдэв. Харин албан бусаар тэрхүү мэдэгдэл нь хүйтэн дайны уур амьсгалд хийгдсэн гэж P5-тай зөвлөлдөхдөө шүүмжилж, улс төрийн хувьд нэг ёсны алдаа болсон гэж үзэж буйгаа мэдэгдсэн. Улмаар Монгол Улс цөмийн зэвсэгтэй ямар ч улс оронтой холбоотны харилцаагүй, P5-тай бүгдтэй нь найрсаг харилцаатай, тэр ч байтугай хоёр хөрштэйгөө найрсаг харилцаа, хамтын ажиллагааны гэрээ тус тусад нь байгуулж, гурван улсын хууль тогтоох дээд байгууллагуудаараа баталгаажуулсан тул улс төрийн тэрхүү “алдааг залруулах” компанит ажил эхлүүлэхээ мэдэгдэж ажилласан. Тэгээд НҮБ-ын хүрээнд болон Үл дэлгэрүүлэх гэрээний хэрэгжилтийг хэлэлцэх бага хурлын бэлтгэл ажлын хүрээнд P5-ын бодлогыг шүүмжилсэн бодлого явуулсан. Тэрхүү бодлогынхоо хүрээнд алдааг залруулах үүднээс НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлөөс Монголын статусын асуудлаар мэдэгдэл гаргаж болох хоёр хувилбарыг АНУ-д санал болгосон. P5 алдаагаа мэдээж хэрэг ойлгосон боловч түүнийгээ илт хүлээн зөвшөөрөөгүй.

Харин хүнд байдлаасаа гарахын тулд НҮБ-ын НБДГ-ын Зэвсэг хураах асуудал эрхэлсэн нэгжээс Монголын статусын бодит байдал, түүнийг цаашид хэрхэн бэхжүүлж болох талаар НҮБ-ын хүрээнээс гадуур P5 болон Монгол Улсын албан бус зөвлөлдөх уулзалтыг Япон улсын Саппоро хотноо 2001 оны есдүгээр сард хийхийг дэмжив. Албан бус уг уулзалтаас Монголын статусыг олон улсын хэмжээнд нарийн тодорхойлоогүй байгааг тэмдэглэж, түүнийг олон улсын эрх зүйн үндэстэй болгохын тулд гурван этгээдийн гэрээ буюу Монгол + P5-ын (өөрөөр хэлбэл: зургаан этгээдийн) гэрээ байгуулахыг зөвлөмж болгов.

Монголын тал тэрхүү зөвлөмжийг НҮБ-ын баримт бичиг болгон тараан баталгаажуулаад зөвлөмжийн дагуу урьд өмнө тавьж байсан 3+3 хувилбараа Орос, Хятад хоёрт санал болгож өөрийн төслийг гаргаж⁸ 2008 онд хөрш орнууддаа уламжилж 2009 онд Женевт гурван талын зөвлөлдөх уулзалтыг хоёр удаа хийв. Монголын талын бэлдсэн гурван этгээдийн гэрээ нь гурван үндсэн тохиролцоог тусгах байв. Нэгд, Монгол Улс бусад улсын цөмийн зэвсгийг буюу тийм зэвсгийн системийн ямар нэгэн хэсгийг нутагтаа байрлуулахгүй, цаашилбал нутаг дэвсгэрээ

⁸ 2008 оны наймдугаар сарын Сайдын Зөвлөлөөр хэлэлцэж баталсан төсөл, удирдамжийг ГХЯ-ны архиваас авч үзэж болно.

хоёр хөрш болон аливаа бусад улсын ашиг сонирхлын эсрэг ашиглуулахгүй. Хоёрт, тэрхүү үүрэг амлалтаа Монгол зөрчихөд хүргэх аливаа үйлдэл хийхэд шууд буюу шууд бусаар нөлөөлөхгүй үүргийг Орос, Хятад авах юм. Гуравт нь, хэлэлцэн тохирогч талууд тус улсын статусыг тал бүрээр бэхжүүлэх чиглэлээр хамтарч ажиллана. Мөн барууны РЗ-ын протокол ёсоор тэд Монгол Улсаас хөрш хоёр оронтойгоо байгуулсан гурван этгээдийн гэрээг дэмжиж хэрэгжүүлэхэд нь хамтарч ажиллахаа илэрхийлсэн байв.

Гурван этгээдийн Женевийн зөвлөлдөх хурал

Монголын талын 16 хуудас бүхий төсөлтэй холбогдуулан Орос, Хятадын тал найман хуудас бүхий 26 асуулга, санал тавьж хариултыг бичгээр гаргаж өгөхийг хүссэнийг Монголын тал тухайн үед нь зөвшөөрч байв.⁹ Гурав дахь хуралдаанд өрнөдийн РЗ-ыг заавал татаж оролцуулах шаардлагатай гэж хөршүүд мэдэгдэж, түүнийг зохион байгуулахыг Монголын талд санал болгов. Төсөл ёсоор Хятад, Орос хоёр Монголын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал болон хоёр улстайгаа тэнцвэртэй харилцах гадаад бодлогынх нь гол зарчим, бие даасан болон эвсэлд үл нэгдэх бодлогыг тус тус хүндэтгэнэ. Мөн тэд тус гэрээний заалтуудыг зөрчих аливаа үйлдлийг үл хийж тус улсын статусыг бэхжүүлэхэд хамтарч ажиллах талаар заасан байв. Хавсралт протокол ёсоор өрнөдийн гурван гүрэн тус гэрээг хүндэтгэж түүнийг бүрэн хэрэгжүүлэхэд дөхөм үзүүлэхийн зэрэгцээ тэд ч мөн тус улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, бие даасан болон эвсэлд үл нэгдэх бодлогыг хүндэтгэнэ гэж заасан байв.

Монгол болон РЗ-ын зөвлөлдөх уулзалт

Монголын тал өрнөдийн РЗ-тай энэ талаар ярилцахад тэд олон улсын гэрээ байгуулах хувилбарыг хүлээж авах боломжгүй гэдгээ дахин мэдэгдэж, харин аливаа өөр хувилбар байвал судалж болох юм гэв. Тэгээд Монголын тал өрнөдийн РЗ-тай зөвлөлдсөний дүнд Монголын статусын асуудлаар Р5-ын хамтарсан болон Монголын тунхаглалыг гаргаж, нэгэн зэрэг гарын үсэг зурахаар ярьж тохиров.

Тохиролцоонд хүрвэл Монголын тал асуудлыг шийдвэрлэсэн гэж үзэх үү гэж Оросын төлөөлөгч Р5-тай хийсэн уулзалтын үеэр зориуд тодруулж асуухад нь “Тэр нь хоёр тунхаглалын эцэслэн тохирох агуулга, хэрэгжилтээс нь хамаарна” гэсэн ерөнхий хариу өгөв. Өөрөөр хэлбэл: Асуудлыг цаашид ч үргэлжлүүлэн хэлэлцүүлж болзошгүйгээ ойлгуулав. Монголын тал Р5-аас 2000 онд гаргасан Р5-ын хамтарсан мэдэгдлийг шинэ төслөөс хасахыг санал болгосон боловч тэд төсөлдөө зориуд тусгаж оруулав. Нэгэнт хамтарсан тунхаглал нь тэдний хамтарсан баримт бичиг болох тул Монголын тал тэр талаар дахин яриа гаргаагүй хүлээн авсан.

⁹ Эдгээр материалыг ГХЯ-ны архиваас авч үзэж болно.

P5-ын хамтарсан тунхаглал, түүний ач холбогдол

Чингээд 2012 оны есдүгээр сарын 17-нд НҮБ-ын Төв байранд хоёр тунхаглалд гарын үсэг зурах арга хэмжээ болов (Монгол Улсын цөмийн зэвсэггүй статус, 2017).

Монгол Улсын статусын талаар гаргасан хоёр тунхаглал тус улсын гадаад аюулгүй байдлыг улс төр, дипломатын аргаар бэхжүүлэхэд чухал алхам болов. Хэдийгээр Монгол Улс бүх улс оронтой, түүний дотор хөрш хоёртойгоо сайн хөршийн харилцаа хөгжүүлж байгаа ч олон улсын харилцааны түүхээс үзвэл шаардлага гарвал их гүрнүүд жижиг улс орны ашиг сонирхлыг эс харгалзан түүнийг өөрийн стратегийн бодлогод овжин ашиглаж ирсэн байдгийг бодууштай.

Цөмийн зэвсэг байгаа цагт тийм зэвсэгтэй гүрнүүд геостратегийн давуу тал олж авах, түүнийгээ хадгалж үлдэх бодлогын хүрээнд хөрш жижиг улс орны нутаг дэвсгэрийг өөрт ашигтай жийргэвч болгон ашиглахыг санаархахгүй гэх газаргүйг Украин дахь дайн, Ойрх Дорнодын байдал, Америк, Израилаас Ираны эсрэг өдүүлсэн дайн харуулж байна. Тийм ч учраас цөмийн зэвсэгтэй гүрнүүд тийм зэвсгээ хорогдуулан хураахын оронд тийм төрлийн зэвсэг, тэдгээрийг тээвэрлэх хэрэгслийг улам боловсронгуй болгох, байршлыг нь нууцлах зорилгоор их далайд байрлуулах зэрэг арга хэмжээ авч олон улсын байдлыг тогтворгүй болгосоор байна. Тиймээс ч тэдний цэргийн номлолд цөмийн зэвсгийн хүчин зүйл, ач холбогдол улам чухал байр эзлэх болж байна.

АНУ-ын НАТО эвслийн холбоотнууд, мөн Япон, Өмнөд Солонгос, Австрали цөмийн зэвсгээр тогтоон барих Америкийн бодлогыг сүүлийн үед дэмжиж, аюулгүй байдлаа түүнд даатгасаар хэвээр байх буюу өөрсдөө цөмийн зэвсэгтэй болох эсэх асуудлыг ярихад хүрч байна. Пуужингийн довтолгооноос хамгаалах нэрээр АНУ нь Европ болон Энэтхэг-Номхон далайн бүсэд стратегийн тэнцвэрт байдлыг алдагдуулж, давуу байдал олж авах бодлого явуулж байгаа нь манай хоёр хөршийн болгоомжлолыг төрүүлсэн хэвээр байна.

Хүйтэн дайны дараа хүчний харьцаа өөрчлөгдөж, ОХУ цөмийн зэвсгийг аюулгүй байдлаа хангах нэгэн чухал хэрэгсэл болгож, түүнийг ердийн зэвсэг бүхий мөргөлдөөнд ч хэрэглэж болзошгүйгээ Украины дайны явцтай холбогдуулан мэдэгдэж, тэр талаар цэргийн номлолдоо зохих өөрчлөлтийг оруулсан.

НАТО эвсэлтэй харьцуулбал ОХУ энгийн зэвсгийн тоогоор түүнээс бага тул цөмийн зэвсгийнхээ тоог АНУ цаашид хорогдуулах тохиолдолд ч Оросын цэргийн бодлогод цөмийн зэвсэг чухал үүрэгтэй хэвээр байхаар барахгүй харин улам ч илүү нөлөөтэй болох төлөв харагдаж байна. Мөн Хятад улс цөмийн зэвсгийнхээ тоо, чанарт урьдынхаас илүү анхаарал тавьж, цөмийн зэвсэг түрүүлж хэрэглэхгүй гэсэн бодлогоо эргэн харах хандлагатай болж, доод түвшинд тогтоон барих цөмийн бодлогоо (minimum deterrence) хязгаарлагдмал түвшинд тогтоон барих (limited deterrence) бодлогоор солих арга хэмжээ авч байна.

Умард Солонгос ч мөн цөмийн зэвсгийн хөтөлбөрөө улам хөгжүүлж, Зүүн Хойд Азид цөмийн зэвсгээр хөөцөлдөх магадлалыг нэмж, тэр ч байтугай Ираны гашуун туршлагаас сургамж авснаар хэрэв Умард Солонгосын удирдлага алагдаж үрэгдвэл зэвсэгт хүчин нь цөмийн зэвсгээ шууд хэрэглэх заалтыг хуульчлав.¹⁰ Цөмийн зэвсгээс ангид байх Монголын бодлого тийм зэвсгээр хөөцөлдөх дажинд НАТО эвсэл болон Беларусийг бодвол нутаг дэвсгэрээ бусдын эсрэг ашиглуулахгүй байх, мөн аль нэг улсын цөмийн зэвсгийн хараа овоонд өртөхгүй байх хүчин зүйл болж буйгаараа манай улс үлгэр жишээ үзүүлж байгааг НҮБ-ын ЕНБД, судлаачид дурдаж байдаг.

Тус улсын өвөрмөц нөхцөлд тохирсон улс төрийн баталгааг P5 гаргаж өгсөн нь олон улсын харилцаанд шинэлэг зүйл болсон. Тэд нэг улс дангаараа цөмийн зэвсгээс ангид статусыг тогтоож, прецедент гаргаж болзошгүйг харгалзан уг статусыг хүлээн зөвшөөрөхөөс бараг 20 гаруй жил зайлсхийж ирснээ 2012 онд Монгол Улсын статусыг арга буюу албан ёсоор хүлээн зөвшөөрч, түүнийг зөрчих аливаа үйлдэлд дөхөм үзүүлэхгүй байхаа хамтдаа зарлан мэдэгдсэн нь олон улсын анхаарлыг татсан. Монголын тал тэрхүү мэдэгдлийг баталгааны хөнгөн агуулга бүхий (security assurance lite¹¹) хэмээн нэрлэж олон улсын харилцаанд нэвтрүүлсэн. Англи 2012 онд хоёр тунхаглалд гарын үсэг зурсан явдлыг бүс нутгийн болон дэлхийн энх тайван, аюулгүй байдалд хувь нэмэр оруулсан үйл явдал болсон гэж үнэлсэн байдаг.

Дэлхийн ирээдүйн төлөөх зөвлөл (World Future Council) гэгч олон улсын ТББ 2013 онд цөмийн эрин үе эхэлснээс хойш цөмийн зэвсгийн аюулыг зайлуулах хамгийн оновчтой бодлогыг шалгаруулахдаа цөмийн зэвсгээс ангид байх Монгол Улсын статусын бодлого, түүний дотор УИХ-аас 2000 онд батлан гаргасан Цөмийн зэвсгээс ангид статусын тухай хуулийг өндрөөр үнэлж тэрхүү бодлогыг “хүндэтгэлтэйгээр тэмдэглэсэн”-ийг зарласан байдаг (World Future Council, 2013). Уг арга хэмжээний талаар тухайн үед нь УИХ-ын удирдлагын сонорт хүргэж тэрхүү сүлжээнд талархал илэрхийлэхийг Цэнхэр Сүлд ТББ-аас санал болгож байсан боловч чингээгүй өнгөрүүлсэн.

Монгол Улсын санаачилга ЦЗБ-ийг шинэ нөхцөлд өргөтгөн бэхжүүлэх үндэс болох талтай

Тус улсын санаачилгыг олон улсын хэмжээнд баталгаажуулж урагшлуулахад дөхөм үзүүлэхийг дэмжсэн хэсэг иргэд 2005 онд Цэнхэр Сүлд хэмээх ТББ-ийг байгуулж, бүс нутгийн хэмжээнд зэвсэг хураах, аюулгүй байдлыг бэхжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг зарим ТББ-тай холбоо тогтоон ажиллаж эхлэв. Тус байгууллага ЦЗБ-ийн давуу болон сул талын асуудлаар 2018 онд судалгаа гаргаж, Монголоос гадна газар зүйн байршил, улс төр буюу эрх зүйн улмаас

¹⁰ Энэ талаар саявтар Өмнөд Солонгосын парламент зарим нэг улсын судлаачдын саналыг авсан бөгөөд энэхүү өгүүллийн зохиогч хувь хүнийхээ хувьд хуваалцсан санаа бодлыг дараах хаягаар орж үзэж болно:

¹¹ Энэ ухагдахууныг олон улсын эрхзүйн эргэлтэд оруулсан

одоогийн ЦЗБ-д оролцох боломжгүй хорь гаруй¹² улс тус дэглэмд нэгдсэнээр сул талыг хааж, цаашид өргөтгөн бэхжүүлэх боломж байгааг тогтоосон. Энэ талаар “Цэнхэр Сүлд” ТББ ЦЗБ-ийн асуудлаар 2021 онд Барселонд болсон Дэлхийн энх тайвны товчооны (International Peace Bureau буюу IPB)-ны Их хуралд, Ковидын байдлын улмаас 2022 онд ЦЗБ-ийн асуудлаар Улаанбаатарын холимог хэлбэрийн бага хурал, мөн цахимаар хийсэн олон улсын 2 семинараар тодорхой хэлэлцүүлсэн. Асуудлыг тодорхой хэмжээгээр хүчлэх үүднээс ЦЗБ-ийн улсууд нь зөвхөн өөрийн бүсийг цөмийн шууд аюулаас урьдчилан сэргийлэхийн зэрэгцээ ер нь цөмийн аюулыг зайлуулах хэрэгтэй хэмээн “Цэнхэр Сүлд” ТББ мэдэгдэж ажиллав.

Асуудлыг бодитойгоор шийдвэрлэхийн тулд НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас ЦЗБ-ийн асуудлаар хоёр дахь түгээмэл судалгаа гаргахыг¹³ Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржоор дамжуулан санал болгож, ТББ-ынхаа хэмжээнд хэд хэдэн ярилцлага зохиосноор Ази-Номхон Далайн Удирдлагын Сүлжээ (Asia-Pacific Leadership Network)-нд дэлгэрэнгүй материал нийтлүүлж хэлэлцүүлэв (Enkhsaikhan, J, 2024).

Улс төрийн болгоомжлол P5 Монголын статусын асуудлаар улс төрийн хамгийн дээд зэргийн амлалт бүхий хамтарсан тунхаглал гаргасныг НҮБ-ын Төв байранд Элчин сайд нарынхаа түвшинд гарын үсэг зурж, тус улсын мэдэгдлийг ч мөн тунхаглалын хэмжээнд гаргаж тэдний адил хэмжээнд гарын үсэг зурахыг тэд арга буюу зөвшөөрснийг улс төрийн хувьд ахиц гэж үзүүштэй. Харин тэгснээр P5 статусын асуудлыг хаах санаархалтай байв. Дээр дурдсанчлан P5-тай хамтран хийсэн хурлын үеэр ОХУ-ын төлөөлөгч манай талд хандаж тавьсан асуултаас тодорхой байв.

Хэрэв манай тал тухайн үед нь P5 хамтарсан тунхаглалд гарын үсэг зурснаар статусын асуудал шийдвэрлэгдсэн гэж үзэж болно хэмээн хариулсан бол НҮБ-ын Ерөнхий Ассамблейн хэлэлцэх хэргийн төлөвлөгөөнд байсан уг асуудал нэгэнт шийдвэрлэгдсэн гэж үзэж хэлэлцэх хэргийн жагсаалтаас хасагдаж, P5 асуудлыг амжилттай шийдвэрлэсэн болж улс төрийн том оноо авч, улмаар манай статусын асуудал улс төрийн ач холбогдлоо аяндаа алдах байв. Тиймээс ч статусын асуудлыг Ассамблейн хэлэлцэх хэргийн төлөвлөгөөнд үргэлжлүүлэн урагшлуулж баталгаар эрх зүйн илүү үндэстэй болгох арга замыг хайж олох шаардлага арга буюу гарав.

Тодорхой амлалт аваагүй улсуудыг татан оруулахын ач холбогдол

ЦЗБ-ийн статусын асуудлыг цаашид дангаараа урагшлуулж зүтгүүлэхийн оронд геополитикийн хувьд манайтай адил нөхцөл байдалд байгаа цэрэг-улс төрийн эвсэл холбоо буюу ЦЗБ-ийн гишүүн биш орнуудыг амлалт аваагүй¹⁴ улсуудыг товчоор амлалт аваагүй гэж нэрлэн ангилж тэднийг ЦЗБ-д татан оруулах

¹² Эдгээрийн тоонд цэрэг-улс төрийн холбоонд буюу нэгэнт байгуулагдаад байгаа ЦЗБ-д нэгдэж ороогүй байгаа (un-committed states) далайд гарцгүй, төвийг сахисан, Өмнөд Азийн бүсийн орнууд, арлын жижиг орнууд, нэн ялангуяа Номхон далайн орнууд, мөн өөртөө засан тохиноогүй нутаг дэвсгэрүүд орж байгаа.

¹³ Official Records of the General Assembly, Thirtieth Session, Supplement No. 27A (A/10027/Add.1).

¹⁴ Энэхүү ухагдахууныг олон улсын харилцааны эргэлтэд оруулж хэрэглэж байгаа.

боломж гарч ирэв. Цөмийн зэвсгийн аюул занал улам нэмэгдэж байгаа өнөө үед ЦЗБ-ийн ач холбогдол ч мөн тэр хэмжээгээр нэмэгдсээр байгаа нь ойлгомжтой. ЦЗБ-ийн сул талыг гаргаж ирэхэд тус улсын статусын бодлого, түүний ач холбогдол аяндаа амлалт аваагүй улсуудын улс төр, эрх зүйн статусын байдлыг танилцуулж улмаар тус улсын статус тэдний хувьд анхны сонгомол кейс болгохын төлөө ажиллахыг “Цэнхэр Сүлд” ТББ шийдвэрлэв.

“Цэнхэр Сүлд” ТББ амлалт аваагүй улсуудын улс төр, эрх зүйн байдал, тэд ЦЗБ-д орсноор буюу эс орсноор олон улсын харилцаанд хэрхэн нөлөөлж болох талаар судалгаа гаргахдаа ЦЗБ-ийн хөгжлийг цаг үеийн хувьд зориуд гурван үе шатанд ангилав. Өнөөг хүртэл байгуулагдаад байгаа бөгөөд эгнээндээ 116 улс орныг нэгтгэсэн таван ЦЗБ-д өөр хоорондоо зарчмын маргаан зөрөлдөөн, нутаг дэвсгэр, хил хязгаарын асуудалгүйн дээр Р5-ын стратегийн ашиг сонирхлыг нэг их хөндөөгүй бүсүүд гэж үзэж нэгдүгээр үеийн бүсүүд (first generation zones) хэмээн тодорхойлов.

Өнөөдрийн байдлаар албан ёсоор хийгдэж байгаа Ойрх Дорнодод цөмийн болон хүнийг үй олноор нь хөнөөх зэвсэггүй бүс байгуулах яриа хэлэлцээ болон албан бусаар яригдаж буй Зүүн хойд Азид болон Хойд мөсөн далайн Арктикт байгуулж болох ЦЗБ-үүдэд орох улс орнууд зарим талаар өөр хоорондоо маргаан зөрчилдөөнтэйн дээр тэдний байршил цөмийн зэвсэгтэй орнуудын стратегийн эрх ашгийг тодорхой хэмжээгээр хөндөж буй тул хоёрдугаар үеийн бүсүүд гэж ангилав.

Энэ хоёр үеийн бүсүүд олон улсын гэрээ хэлэлцээрт тулгуурласан, тэдгээрт цөмийн зэвсэгтэй гүрнүүд эрх зүйн үндэстэй баталгаа гаргаж өгөх учиртай нь ойлгомжтой. Тэгвэл олон улсын гэрээ байгуулах боломжгүй улсуудыг ЦЗБ-ийн гурав дахь үеийн бүсэд ангилан оруулж, тэд Монголын нэгэн адил цөмийн зэвсгийн холбогдолтой асуудал, бодлогын талаар дотооддоо хууль тогтоомж гарган бодлогоо тодорхойлж, бүс нутгийнхаа тогтвортой байдлыг хангахад хэрхэн оролцож болох талаар Р5-тай зарчмын тохиролцоонд хүрч, улс төрийн тэрхүү тохиролцоогоо НҮБ-ын НБДГ-ын Зэвсэг хураах газарт бүртгүүлэх замаар бодлого, статусаа олон улсын улс төрийн хэмжээнд баталгаажуулахыг “Цэнхэр Сүлд” ТББ санал болгож, ТББ-уудын хэмжээний лекц яриа, семинарт тайлбарлаж ажиллав. Тухайлбал: Нобелийн энхтайвны шагналыг 1910 онд хүртсэн Дэлхийн Энх Тайвны Товчоо (International Peace Bureau), Зүүн Азийн Сангийн сэтгүүл Global Asia, Ази-Номхон Далайн Лидерүүдийн Сүлжээ (Asia-Pacific Leadership Network – APLN), мөн 2022 онд ЦЗБ-ийн асуудлаар Улаанбаатарт холимог хэлбэрээр зохион байгуулсан олон улсын бага хурал, КОВИД-ын ид үед цахимаар хийсэн олон улсын 2 семинараар хэлэлцүүлж дэмжүүлсэн. 2024 онд гарсан Энэтхэг-Номхон далайн бүсийн хамтын Аюулгүй байдлын судалгаа (Common Security in the Indo-Pacific Region, 2024)-нд эдгээр санааг тодорхой тусгасан. 2027 онд гаргахаар боловсруулж буй Хамтын аюулгүй байдлын шинэчилсэн судалгаанд дээрх

санаагаа илүү дэлгэрэнгүй оруулахаар олон улсын судлаачидтай “Цэнхэр Сүлд” ТББ ярилцаж байна.

Олон улсын харилцаанд үйлчилдэг бичигдээгүй хууль Олон улсын харилцаанд үйлчилдэг бичигдээгүй хуулийн нэг бол улс орнууд юуны өмнө өөрийн эрх ашгийг боддог явдал юм. Бусдыг бодвол одоо АНУ-ын Засаг захиргаа Америкийг нэгд тавих бодлогоо илт зарлаад зарим талаар бодлогоо бусдад тулгах гэж ажиллаж байгаа нь шүүмжлэлд өртөж байна. Хэдийгээр НҮБ-ын Дүрмийн 24-ийн 1-д зааснаар НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл, нэн ялангуяа P5 олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сахиулахад гол үүрэг хариуцлага хүлээж түүнийгээ бүх гишүүний өмнөөс хэрэгжүүлэх үүрэгтэй боловч тэдний бодлогод явцуу ашиг сонирхол нь давамгайлдаг талтайг хэн бүхэн мэднэ. Бичигдээгүй хуулийн дагуу цөмийн зэвсэгтэй улс орнууд өөр хоорондоо зориуд дайтахгүй нь ойлгомжтой.

Харин хөндлөнгийн хүчин зүйлс, учир шалтгаанаас болж аргагүй эрхэнд зэвсэгт мөргөлдөөнд татагдан орох, холбоотноо хамгаалах, геополитикийн буюу гео-эдийн засгийн давуу тал олж авах буюу тийм байдлаа хамгаалах зэргээр хүч хэрэглэхийг үгүйсгэх аргагүй. Тиймээс *lupus non mordet lupum* буюу “Чоно чоноо барьдаггүй” хэмээх бараг анхааруулга буюу сургамж болсон зүйр үгийг нэн ялангуяа цөмийн зэвсгээр дахин хөөцөлдөхөөр болж буй өнөө үед санаж явахад илүүдэхгүй. Сургамжийн тэр үг цөмийн зэвсэгтэй улсуудад шууд хамаарна. Өөрөөр хэлбэл: Цөмийн зэвсэгтэй улс болон тэдний шүхэрт байгаа улсууд, мөн ЦЗБ-д хамрагдаж буй улсуудаас бусад нь буюу амлалт аваагүй улсууд их гүрнүүдийн маргаан зөрчилдөөнд татагдан орж ашиглагдаж хохирохгүй гэх баталгаагүй болж байна.

Европ болон Ойрх Дорнодод гарч буй дайны хямрал Зүүн Хойд болон Зүүн Азид гарахыг үгүйсгэх аргагүй. Бүр тодорхой яривал хүйтэн дайны дараа буй болж байсан нэг туйлт үе дуусгавар болох хандлага гарч, цөмийн зэвсэгтэй улсууд тийм зэвсэггүй улс орны газар зүйн байршил болон цаг хугацааны хүчин зүйл буюу аливаа өөр бусад давуу талыг цөмийн бодлого, номлолдоо тусгаж ашиглах гэж санаархахыг үгүйсгэх аргагүй. Тэд амлалт аваагүй улсын иргэний зориулалт бүхий техник хэрэгслийг бусдад дарамт шахалт үзүүлэх буюу тэрхүү зэвсгээ илүү оновчтой хэрэглэхэд ашиглахыг бодох, цаашилбал холбоотон биш улсын зэвсэг техникийг бусдын цөмийн зэвсэг, тэдгээрийн байршил, тийм зэвсэг тээвэрлэгч хэрэгсэлд хяналт тавих, тагнуулын ажиллагаа явуулах, зэвсгээ онилох зэрэгт тэднийг татан оруулж ашиглахгүй гэх газаргүй болж байна.

Олон улсын харилцаа улс төрийн хувьд хэдэн туйлт ертөнц рүү шилжих эхлэл тавигдаж, дэлхийн хүн амын тоо нэмэгдэхийн хэрээр байгалийн баялгийг ашиглах хэрэгцээ шаардлага түргэн өсөж, 2050 он гэхэд өнөө үеийнхээс хэд дахин нэмэгдэх тооцоо гарсан байдаг. Их гүрнүүдийн хувьд далайн амьд болон амьд бус баялаг, мөн тэнгис далайн орон зайг өөрийн хараа мэдэлд байлгах буюу авах бодлогынхоо хүрээнд Далайн эрхийн тухай 1982 оны конвенц ёсоор дэлхийн гадаргын бараг 15 хувь нь мэдэлд нь байгаа, хүн ам нь хэдхэн арван мянгаар тоологддог арлын

жижиг орнуудын эдийн засгийн онцгой бүс (Exclusive Economic Zone буюу товчоор EEZ)-ийг давуу эрхтэйгээр ашиглахыг санаархах нь ойлгомжтой. Энэ нь яваандаа АНУ, Хятадын өрсөлдөөний талбар болж, Номхон далайн баруун хэсгийн сөргөлдөөний эх үүсвэр болон хувирч болзошгүй. Тиймээс амлалт аваагүй улсууд ЦЗБ-д эс нэгдвэл тэдний байгалийн баялаг, далай дахь стратегийн ашигтай байршил нь ЦЗБ-ийн Ахиллесийн тавхай гэгч нь болж их гүрнүүдийн тэмцэл, сөргөлдөөнд ямар нэгэн хэмжээгээр татагдан орж, хохирох магадлал нэмэгдэж болохыг Ираны эргэн тойрны асуудал тод томруун харуулж байна. Тиймээс чоно хонины санаа бодлыг харгалздаггүй, эелдэг чоно гэж байдаггүй харин тэвчээртэй чоно байдаг гэдгийг өнөө үед санаж явахад илүүдэхгүй. Иймд цөмийн зэвсэггүй улсууд олон улсын эрх зүйг бэхжүүлж, улс орнуудын үүрэг, нэхэл хариуцлагыг нэмэгдүүлсэн зүйл анги бүхий заалтыг олон улсын буюу бүс нутгийн хэмжээний эрх зүйн баримт бичгүүдэд тусгаж хатуу мөрдүүлэх цаг тулгарч байна.

XIX зуунд Төв Азид нөлөөгөө тэлэх гэсэн Англи, Оросын бодлого буюу тэр үеийн улс төрийн их тоглоомын адил өрсөлдөөн өнөөдөр Энэтхэг-Номхон далайн бүсэд газар авч байна. Тиймээс Америк, Хятад хоёр амлалт аваагүй орнуудтай харилцахад баримтлах бодлогын талаар НҮБ-ын Дүрмийн зарчим, үзэл санааны дагуу тохиролцоонд хүрэх нь тогтвортой байдлыг бэхжүүлж хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чухал хүчин зүйл болно. Иймд амлалт аваагүй орнууд Монголын адил өөрийн нутаг дэвсгэрийг бусдын аюулгүй байдал хийгээд ашиг сонирхолд сөргөөр нөлөөлүүлэхгүй байлгах талаар хууль тогтоомж гаргаж, тэдгээрийг хүндэтгэх талаар P5-аар, нэн ялангуяа Америк, Хятадаас үүрэг амлалт гаргуулж авах нь тогтвортой байдлыг бэхжүүлэхэд тэдний оруулах тодорхой хувь нэмэр болно.

ЦЗБ-ийн хоёр дахь судалгаа гаргах шаардлага: Манай улс 2013 онд ЦЗБ-ийн асуудлаар хоёр дахь түгээмэл судалгааг хийлгэх саналыг Ерөнхий Ассамблейд тавьсан.¹⁵ Мөн ЦЗБ-ийн орнууд ч тийм бүсийг нэмж байгуулах, нэгэнт байгуулсан бүсүүдийг бэхжүүлэх үүднээс хоёр дахь судалгааг гаргуулахыг дэмжиж ажилласны дүнд 2024 оны 12 дугаар сарын 3-нд Ерөнхий Ассамблей ЦЗБ-ийн асуудлаар хоёр дахь судалгааг гаргах тухай тогтоолыг батлав.¹⁶ Түүний дагуу гишүүн орнууд болон асуудал эрхэлсэн олон улсын болон зарим ТББ-ыг ЦЗБ-ийн болон тэдний цар хүрээний талаарх саналаа НҮБ-ын НБДГ-т бичгээр гаргаж өгөхийг хүсэж, уг асуудлаар 25 хүртэл тооны нарийн мэргэжлийн судлаачдын ажлын хэсгийг байгуулж ажиллуулахаар шийдвэрлэсэн. Тогтоолын дагуу 16 улс, олон улсын тав, төрийн бус зургаан байгууллага саналаа бичгээр тус тус гаргаж хүргүүлсэн бөгөөд аливаа асуудлаар гишүүн орнуудын санаа бодол хамгийн чухал байдаг. Гэтэл Монголын Засгийн газар санаа бодлоо бичгээр илэрхийлээгүй тул статусаа бэхжүүлэх талаарх санаа бодлоо тайлбарлаж урагшлуулах чухал боломжийг алдсан нь тун харамсалтай. Тэгвэл 2022 онд Монгол Улсын Ерөнхийлөгч Ерөнхий Ассамблейд ерөнхий санал шүүмжлэлд үг хэлэхдээ “Цөмийн зэвсэггүй бүс нутгийг бий болгох нь хамгийн зөв, үр дүнтэй зам мөн хэмээн Монгол Улс үздэг” гэж цохон тэмдэглэсэн бол 2025 онд

¹⁵ A/68/PV.11 тоот баримт бичгийг үзнэ үү.

¹⁶ UNGA resolution of 2025

цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх, ЦЗБ-ийг өргөжүүлэх чиглэлд гаргасан дэлхийн улс орнуудын хамтын хүчин чармайлт талаар өнгөрөх учиргүйг дахин цохон тэмдэглэж тус улс цөмийн аюулыг зайлуулахад бодит хувь нэмэр оруулж буй, цөмийн зэвсгээс ангид байх бодлого, үйл ажиллагаагаа цаашид ч тууштай даган мөрдөж дэмжихээ нотолсон байдаг. Гэвч Засгийн газар тэр талаар санал бодлоо илэрхийлээгүй өнгөрснийг бодлоготой биш харин ажлын хариуцлага алдсантай холбож үзсэн ч тун харамсалтай байлаа. Харин “Цэнхэр Сүлд” ТББ Ерөнхий Ассамблейн тогтоолын дагуу саналаа бичгээр гаргаж хүргүүлсэн.¹⁷

Засгийн газар хэдийгээр санаа бодлоо бичгээр илэрхийлээгүй боловч статусыг цаашид бэхжүүлэх үүднээс мэргэжилтнийхээ нэрийг дэвшүүлсний дүнд энэхүү өгүүллийг тэрлэгч НҮБ-аас 2025 онд томилсон 15¹⁸ нарийн мэргэжлийн судлаачдын тоонд орж, 2026 оны долоодугаар сар хүртэл ажиллаж тус улсын өвөрмөц статусын олон улсын ач холбогдлыг тайлбарлан таниулах, түүнийг урагшлуулах талаар ажиллах завшаан тохиолдов.

НҮБ-ын НБДГ судлаачдыг шилж томилохдоо Монгол Улсаас цөмийн зэвсгээс ангид статусын талаар баримталж ирсэн тууштай бодлого, тэрхүү бодлогын талаарх НҮБ-ын ЕНБД болон зарим орны үнэлгээ, ЦЗБ-ийн цар хүрээг эргэн харж Ахилессийн тавхайгүй болохын тулд түүнд хамруулж болох улс орнуудыг татаж оролцуулах боломжийг бодолцсон биз.

ЦЗБ-ийн бүтцийн үндсэн доголдол, түүнээс гарах арга зам

Цөмийн зэвсэггүй дэлхий ертөнцийг буй болгоход цөмийн зэвсэгтэй орнууд өөрсдийн зэвсгийг хураан устгаж, харин цөмийн зэвсэггүй улсууд тийм зэвсгээс бүрэн татгалзсан зохион байгуулалтад орсон байх учиртай. Гэвч амлалт аваагүй улсуудыг ЦЗБ-д хамруулаагүй байгаа нь түүний бүтцийн гол доголдол болохыг Монгол Улсын бодлого болон Цэнхэр Сүлд ТББ-ын судалгаа тогтоож, ЦЗБ-ийн хөгжлийн шинэ хуудсыг нээж байна хэмээн үзэх үндэстэй. Өөрөөр хэлбэл: Монголын статус нь нэг улсын онцлогтой холбоотой асуудал биш харин амлалт аваагүй улсуудын ангилалд орсон улс орнуудын нийтлэг ашиг сонирхолд нийцсэн зарчмын чанартай асуудал юм. Энэ бүлэг улсыг ЦЗБ-д оруулаагүй байгаа нь түүний гол доголдол мөн бөгөөд түүнийг арилгаж цар хүрээг нь тэлж бэхжүүлэх боломж гарч байна. Монгол Улс хэдийгээр олон улсын гэрээ байгуулах боломжгүй ч үндэсний хууль тогтоомж гаргаж, улс төр, дипломатын тууштай бодлого явуулснаар олон улсын дэмжлэгийг авч статусаа Ерөнхий Ассамблейн удаа дараагийн тогтоолоор баталгаажуулж, 2012 онд цөмийн зэвсэгтэй улсуудаас хөнгөн агуулга бүхий улс төрийн хамтарсан баталгааг гаргуулж авсан (security assurance lite). Тиймээс улс төрийн тэрхүү ололтдоо үндэслэн статусаа ЦЗБ-ийн өвөрмөц хэлбэр хэмээн хүлээн зөвшөөрүүлж чадвал амлалт аваагүй улсууд Монголын жишгээр ЦЗБ-ийн гурав

¹⁷ А/79/950

¹⁸ Хэдийгээр тогтоолд 25 хүртэл тооны мэргэжилтнүүдийг оролцуулахаар заасан байсан боловч судалгаа нь нэгэнт Ойрх Дорнодын асуудлыг ярих тул АНУ тийм судалгаа гаргахыг үл дэмжиж байдаг тул түүнд зардал гаргахаас татгалзсан тул тоог аргагүй эрхэнд 15 болгож бууруулсантай холбоотой.

дахь тулгуур чулууг босгох буюу гуравдугаар үеийн бүсийг байгуулж, ЦЗБ-ийн бүтцийн доголдлыг бүрэн арилгана.

Их гүрнүүдийн өсөн нэмэгдэж буй сөргөлдөөнд амлалт аваагүй улсуудын байршил, тэдний бодлого тодорхой хэмжээгээр нөлөөлж болох тул тэднийг ЦЗБ-д хамруулах нь олон улсын харилцааг илүү ойлгомжтой, цэгцтэй, улмаар илүү тогтвортой болгоход хэрэгтэй юм. ЦЗБ-д хамрагдаж бүтцийн доголдлыг арилгахад цорын ганц туршлагатай бөгөөд Р5-аас улс төрийн баталгаа авсан Монгол Улс энэ бүлэг улсад, цаашилбал бүтцийн доголдлыг арилгахад чухал үүрэг гүйцэтгэж болох юм. Энэ талаар Монголын судлаач хэлэхдээ цөмийн зэвсэгтэй орнууд өөр хоорондоо цөмийн зэвсгээр дайтаж өөрсдөө хохирохыг огт бодохгүй нь ойлгомжтой. Тэд анх цөмийн зэвсэгтэй болохдоо бусад улсын цөмийн довтолгооноос өөрсдийгөө болон холбоотнуудаа хамгаалах зорилготой гэж тайлбарладаг байсан. Харин өнөө үед зарим нь цаг үеийн байдлаас шалтгаалж, цөмийн зэвсгээ цөмийн зэвсэггүй улс орны эсрэг хэрэглэхгүй гэж хэлэх боломжгүй гэж албан ёсоор мэдэгдэж байна. Украин, Ираны дайны дараа үйлдвэр хөгжсөн зарим орны цөмийн бодлогод өөрчлөлт гарах төлөвтэй байна. Тэр ч байтугай АНУ-ын зарим холбоотон түүний аюулгүй байдлын баталгаанд эргэлзэж, өөрсдөө зэвсэгтэй болох санааг цухалзуулах болж байна. Тийм нөхцөлд олон улсын хуулиар зохицуулагдаж хамгаалагдаагүй байгаа орнуудыг ЦЗБ-д хамруулж, цөмийн зэвсэгтэй орнуудаар тогтвортой байдлыг хангах талаар үүрэг хүлээлгэх хэрэгтэй болж байна. Тийм үед ЦЗБ-ийг өргөжүүлэн бэхжүүлэх асуудлыг илүү хүчтэй урагшлуулах улс төрийн аятай нөхцөл бүрдэнэ гэв.

Амлалт аваагүй улс орныг ЦЗБ-д оруулахгүй байгаа нь улс орон бүр НҮБ-ын Дүрмийн 51 дүгээр зүйлийн дагуу өөрийгөө дангаар буюу бусадтай хамтран батлан хамгаалах эрхийг зөрчиж байгаа юм. Өөрөөр хэлбэл: тэдгээр улсыг ЦЗБ-ийн дэглэмд хамруулахгүй бол тэр нь ЦЗБ-ийн үзэл баримтлалын Ахиллесийн тавхай гэгч болж байгааг судлаачдад анхааруулж асуудлыг нухацтай хэлэлцэхийг санал болгосон. Чингээд хэлэлцүүлэхээр оруулсан баримт бичигтээ ЦЗБ-ийн талаар 1975 онд батлагдсан ЦЗБ-ийн тодорхойлолт, үзэл баримтлалыг энэ зууны шинэ нөхцөлд тохируулан шинэчлэх шаардлага байгааг анхааруулав. ЦЗБ-ийн анхны судалгааг гаргахдаа тийм бүсийг бүлэг улсаас гадна бүхэл бүтэн тив байтугай нэг улс ч дангаараа байгуулж болно гэж тэмдэглэсэн байдаг. Түүнээс хойш өнгөрсөн хагас зуун жилийн хугацаанд зөвхөн Монгол Улс тийм заалт байдгийг гишүүн орнуудад сануулж ирсэн бөгөөд түүний дагуу улс орноо ЦЗБ болгох саналыг НҮБ-ын Ерөнхий Ассамблейд тавьж цөмийн зэвсэгтэй орнуудаар аюулгүй байдлын баталгаа гаргуулах талаар ажиллаж ирснийг тайлбарласан. Цөмийн зэвсэгтэй орнууд өөрсдийн ашиг сонирхол, түүний дотор цөмийн зэвсэгтэй бусад улсын зэвсгийн төрөл, байршил, хөдөлгөөн маневрыг уян хатан байлгах цэргийн шаардлага, холбоотнуудаа хамгаалах талаар авсан үүргээ бодолцох, мөн шаардлага гарвал тийм зэвсэггүй зарим улсын байршлыг ашиглах боломжийг харгалзан нэг улс дангаараа ЦЗБ байгуулах явдлыг дэмжихгүй байгаа. Хүйтэн дайны үеийн хандлага, бодлого гэж харж үзэж шинэ нөхцөл байдалд тохируулан бодлогоо өөрчлөх шаардлага гарч байгаа хэдий ч цөмийн зэвсгийнхээ

бодлогыг ердийн зэвсгийн бодлоготойгоо уялдуулан цөмийн дайн мөргөлдөөн гарч болох магадлалыг нэмсээр байна.

Хэрэв амлалт аваагүй улсууд ЦЗБ-д хамрагдаж цөмийн зэвсэгтэй улсуудаар тодорхой үүрэг амлалт гаргуулж авбал тэр нь олон улсын тогтвортой байдалд эергээр нөлөөлөхийг дээр өгүүлсэн. Тиймээс тэдгээр улсыг ЦЗБ-ийн дэглэмд хамруулах нь чухал юм гэж тэмдэглээд Монголын статусыг ЦЗБ-ийн нэг хэлбэр мөн болохыг хэлэлцэж, мэргэжилтнүүдийн хэмжээнд хүлээн зөвшөөрөхийг санал болгоод байна. Энэ 7 дугаар сард болох мэргэжилтнүүдийн гурав дахь буюу сүүлчийн хуралдаанаар тус улсын статусын талаар гаргасан судалгаа, санал санаачилга, цаашид Монголын адил буюу төстэй байдалд байгаа амлалт аваагүй улсуудын асуудлыг товч боловч хэлэлцэнэ. Ингээд мэргэжилтнүүдийн илтгэлийг наймдугаар сард багтааж эцэслэн гаргаж, гишүүн орнуудын саналыг бичгээр авна. Монгол Улсын Засгийн газар мэргэжилтнүүдийн илтгэл, гарсан зөвлөмжийн талаарх саналаа бичгээр гаргаж өгөх боломжийг дахин алдаж хэрхэвч болохгүй. Бодит байдлаас үзвэл цаг хугацааны хүчин зүйлээс болж энэ удаагийн судалгаа шинээр байгуулж болох ЦЗБ-үүдийн талаар маш товч илтгэл гарахаар болж байна. Тиймээс хэдийгээр шинээр байгуулж болох ЦЗБ-ийн талаарх санал, зөвлөмж товч байх хэдий ч шинэ судалгааг энэ чиглэлээр ажилладаг мэргэжлийн судалгааны олон улсын байгууллагаар гаргуулж, НҮБ-ын ЕНБД-д уламжлан гишүүн орнуудад толилуулна. Ийнхүү тэдний санаа бодлыг сонсох нь олон улсын энх тайван, тогтвортой байдлыг хангах гол үүргийг гүйцэтгэхэд хувь нэмэр болох бөгөөд тийм утга санаа бүхий тогтоолыг Ерөнхий Ассамблейгаар гаргуулах нь ЦЗБ-ийг өргөжүүлэн бэхжүүлэхэд чухал алхам болно гэдэгт итгэж, мэргэжилтнүүдтэй хамтран ажиллана. Гэхдээ тэдний дотор цөмийн зэвсэгтэй орнуудын болон тэднийг дэмждэг зарим улсын мэргэжилтнүүд байгааг мартаж үл болно.

Ерөнхий дүгнэлт, зарим санал

Монголын статусын асуудал Ерөнхий Ассамблейгаар хэлэлцэгдэж ирсэн бөгөөд Р5 2012 онд гаргасан хамтарсан тунхаглалдаа статусын асуудлаарх тогтоолыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхэд хамтран ажиллахаа нотолсон. Тэгснээрээ тэд Монголын асуудлыг хэлэлцэх хэргийн төлөвлөгөөнд оруулах, тус улсын гадаад аюулгүй байдлын асуудлыг олон улсын хамтын нийгэмлэгийн хараа хяналтад байлгахыг одоогоор дэмжсээр байна.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөл (ҮАБЗ) цөмийн зэвсгээс ангид байх статусын хэрэгжилтийн талаар тусгайлан дүн шинжилгээ хийж, түүнийг цаашид хэрхэн урагшлуулах талаар бодитой, барьцтай зөвлөмж гаргах хэрэгтэй байна. Тухайлбал: асуудлыг тус улсын зөөлөн хүчний нэг чухал хэсэг болгосноор ЦЗБ-ийн гурав дахь тулгуур чулууг тус улсынхаа туршлагыг үндэслэн тавилцаж, улмаар 3 дахь үеийн бүсийг байгуулалцахад эхнээс нь идэвхтэй оролцож, түүнийгээ НҮБ-ын Энхийг сахиулагч хүчнийхээ зэрэгцээ улс орны нэр хүнд, гадаад бодлогын бодит үр өгөөжийг нэмэгдүүлж, практик амьдралд XXI зууны Pax Mongolica-ийн нэгэн

илэрхийлэл болгож ажиллаж болно. Тэгвэл тус улсын гадаад аюулгүй байдлын асуудал НҮБ-ын Ерөнхий Ассамблейн хэлэлцэх хэргийн төлөвлөгөөнд бодитой үлдэнэ. Хэрэв асуудлыг “тодорхой эзэнгүй” зөнд нь орхивол НҮБ-д хэлэлцдэг “хөвсөн” олон асуудлын нэг болж, жам ёсоороо бүдгэрэн НҮБ-ын архивт шилжинэ. Тиймээс ҮАБЗ энэ асуудлаар зарчмын зөвлөмж гаргаж түүнийг дэмжихийн зэрэгцээ хэрэгжилтийн явцыг нь хариуцаж, 2 жил тутам илтгэдэг нэгж байгуулснаар үр дүнт нь нийт ард түмэнд болон олон улсад мэдээлж байвал үр дүнтэй болно.

Одоогийн статусыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхтэй холбогдсон зарим санал:


- Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид статусыг урагшлуулах асуудал гацаанд ороод байгаа нь Ерөнхий Ассамблейн тогтоолуудын агуулгаас тодорхой байна. Хэрэв асуудалд ямар нэгэн ахиц гарахгүй бол НҮБ-ын гишүүд уг асуудал үндсэндээ шийдвэрлэгдсэн гэж үзэж, Ерөнхий Ассамблейн хэлэлцэх хэргийн төлөвлөгөөнөөс хасах хандлага гарч болзошгүйг анхаарах;
- Украиньг тойрсон дайн, Израил-Хамасын сөргөлдөөн, Америк, Израилаас Ираны эсрэг өдүүлсэн дайн, Солонгосын хойгийн тогтворгүй байдал болон Өмнөд Хятадын далайн орчны эмзэг байдал зэрэг олон улсын харилцаанд гарч буй хурц асуудлуудыг НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл болон Ерөнхий Ассамблей зохицуулж шийдвэрлэж чадахгүй байгаа өнөөгийн нөхцөлд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн үйл ажиллагаа, түүний Байнгын гишүүдийн (өөрөөр хэлбэл: P5-ын) үйл ажиллагааг шүүмжлэхийн дээр Ерөнхий Ассамблей ч өөрөө маш олон асуудлыг үр дүн багатай хэлэлцэж, цаг дэмий үрж байгаа, гаргаж буй тогтоолуудын хэрэгжилт сул байгааг НҮБ-ыг шинэчлэх асуудалтай шууд холбож, улмаар Ерөнхий Ассамблейгаар хэлэлцэгдэж буй 170 орчим асуудлын заримыг нь хэлэлцэх хэргийн төлөвлөгөөнөөс хасах санал гарвал P5 болон тэдний холбоотнууд нэг улсын санаачилгаар хэлэлцэж ирсэн Монголын статусын асуудлыг хасахыг санал болгохыг үгүйсгэхгүй. Тиймээс их гүрнүүдийн зөрчилдөөн, нэн ялангуяа Энэтхэг-Номхон далайн бүсэд Америк-Хятадын өрсөлдөөн ширүүсэх төлөвтэй байгаа энэ үед амлалт аваагүй байгаа орнуудын хувьд өөрсдийнх нь эрх ашигт нийцсэн, бүс нутгийн тогтвортой байдлыг бэхжүүлэхэд дөхөм үзүүлэхийн жишээ болох тул түүнийг нь идэвхтэй дэмжих;
- Монголын Засгийн газар өөрийн бодлого, байр суурийг олон улсын хамтын нийгэмлэгт тодорхой тайлбарлан таниулж байх нь амжилтынх нь чухал үндэс болох тул асуудлыг анх хэлэлцүүлж байх үед Засгийн газраас уг асуудлаар үе үе мэдэгдэл буюу меморандум бичиг гаргаж оновчтой дипломат арга хэрэгслээ болгон ашиглаж байсныг сэргээх. Жижиг улс НҮБ-ын индэр, боломжийг тийм хэлбэрээр ашигладгийг анхаарах;
- “Цөмийн зэвсэггүй бүсүүд ба Монгол Улсын холбоо” (NWFZM) хэмээх эгнээндээ 117 улс орныг нэгтгэсэн энэхүү механизм байр сууриа сэргээн бэхжүүлэхэд анхаарах хэрэгтэй. Чингэхдээ Монголын тал 2010 онд гаргасан

улс төрийн алдаанаасаа сургамж авч, үл бүтэх асуудлыг сайн дураараа санаачлан өөрийгөө болон холбооны үйл ажиллагааг хүндрүүлэхээс зайлсхийх;

- Ерөнхий Ассамблейн тогтоолд статусыг сайшаан дэмжсэн (welcomes Mongolia's status), өөрөөр хэлбэл түүнийг албан ёсоор хүлээн зөвшөөрсөн тодорхой заалтыг тогтоолд тусгаваас ЦЗБ-ийн дэглэмд ганц улс дангаараа ч байж болох улс төрийн ойлголтыг тогтоолоор бататгах нь манай улс болон манайтай адил амлалт аваагүй бусад улс орон НҮБ-ын бусад гишүүн, олон улсын байгууллагууд, цөмийн зэвсгийг эсэргүүцдэг төрийн бус байгууллага, холбоодтой илүү үр дүнтэй хамтарч ажиллах боломж нээгдэнэ.
- ЕНБД-аас манай статусын асуудлаар гаргадаг илтгэлийг бэлтгэхэд Монголын тал нэн идэвхтэй оролцож тогтоолын заалтуудтай холбогдсон асуудлуудын талаар өөрийн санаа бодлыг анхны хэдэн илтгэлийг бэлтгэхэд оролцож байсны адил идэвхтэй оролцох. Өөрөөр хэлбэл: илтгэлийг тус улсын статус болон гадаад аюулгүй байдлыг бэхжүүлэхэд хандуулж тэр талаар НҮБ-ын хүрээнд өргөн хэлэлцүүлэг өрнүүлдэг болгох;
- Ерөнхий Ассамблейн тогтоолд тусгагдсан “Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдал, экологийн тогтвортой байдал”-ыг бэхжүүлэхэд хамтарч ажиллахыг гишүүн орнуудад уриалж, түүнийг нь хэрэгжүүлэхэд тус дэм үзүүлэхийг ЕНБД болон холбогдох байгууллага, нэгжид хандаж гаргасан заалтын дагуу тодорхой ажил зохиож байх. Тухайлбал: статусын асуудлаар гаргах ЕНБД-ын дараагийн илтгэлд статусыг урагшлуулах талаар тодорхой дурдахдаа тус улсын далайд гарцгүй асуудлаар бие даасан судалгаа гаргуулж хэлэлцүүлэг өрнүүлэх, НҮБ-ын нэг жилийг далайд гарцгүй орнуудын үйл ажиллагааг дэмжсэн жил болгох талаар бодож болох юм. Чингэх нь Монгол Улсын гадаад бодлогод тэнгис далайд, цаашилбал олон улсын зах зээлд гарахад тулгардаг саад бэрхшээлийг олон улсын хамтын нийгэмлэгт ойлгуулахад дөхөмтэй болно. Тэгснээрээ Монголд байгуулсан Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын олон улсын судалгааны төвийн үр нөлөөг өөрийн орны жишээн дээр бодитоор харуулж, нэг сумаар хоёр зорилтыг биелүүлж болно. Дараагийн нэг илтгэлд Монгол Улсаас уур амьсгалын өөрчлөлт, саад бэрхшээлийг даван туулах үүднээс Монгол Улс цөлжилттэй тэмцэхэд тэрбум мод тарьж байгаа компанит ажил, гарч байгаа үр дүн, хүндрэл бэрхшээл, энэ талаар хамтын нийгэмлэгийн зүгээс ямар улс, байгууллага хэрхэн тусалж байгаа талаар өгүүлэх нь аль аль талдаа практик ашигтай болно;
- Монгол Улсын Их Хурал тус улсын цөмийн зэвсгээс ангид статусын чанарыг шинэ шатанд гаргах талаар 2015 онд 60 тоот тогтоол гаргасан байдаг. Арав дахь жилийнхээ нүүрийг үзэхийн өмнө УИХ Цөмийн аюулгүй байдлын тухай 1994 оны конвенц, Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлтийн протокол болон Цөмийн бага хэмжээний шинэчилсэн протоколд нэгдэж орох шийдвэр

гаргалаа. Тэр нь чухал бөгөөд сайшаалтай. Гэвч тус улсын аюулгүй байдалтай шууд холбоотой байж болох олон улсын эрх зүйн чухал акт болох Ашигласан түлшний болон цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй ажиллагааны тухай 1997 оны конвенцод нэгдэж орохоос зайлсхийж байгааг ойлгоход хэцүү байна. Учир нь гэвэл уг конвенцод нэгдэж орсноор манай улс хөрш хоёр орны цөмийн ашигласан түлшний талаар баримталж байгаа бодлого, цаашид авахаар төлөвлөж байгаа арга хэмжээний тухай зиндаа нэгтний (peer-review) зарчмын дагуу тодорхой мэдээлэл авснаар конвенцод нэгдэж орсон улсуудын хэмжээнд яриа хэлэлцүүлэг өрнүүлэх боломжтой болох юм. Тиймээс учир нь тодорхойгүй орхигдуулсан уг конвенцод цаг алдалгүй нэгдэн орж, хөрш орнуудынхаа болон ялангуяа бараг хөрш залгаа Казахстаны цөмийн цахилгааны бодлого, ашигласан түлшээ чухам хаана байрлуулахаар болж байгаа талаар тодорхой мэдээлэлтэй болж, өөрийн ашиг сонирхолд нийцсэн бодлого явуулах чухал боломж нээгдэнэ;

- ГХЯ-ны цахим хуудасны “Баримт бичиг, санаачилга” хэсэгт статусын холбогдолтой ямар нэгэн баримт байхгүй гагцхүү зөвхөн 4-5 өгүүлбэр орсон байгаа нь тун хангалтгүй. Тиймээс ч гадаадынхан статустай холбогдсон мэдээллийг Монголын ГХЯ-аас биш харин агуулгаар хавьгүй баялаг мэдээлэлтэй цахим хуудас, эх сурвалжаас авдаг тул Монгол Улс энэ чиглэлээр чухам юу хийж ирсэн, ямар бодол, төлөвлөгөөтэй байгааг олж мэдэх боломжгүй байгаад зарчмын дүгнэлт хийж ажиллах.



Mongolia's nuclear weapon free status as a means to expand and strengthen the NWFZ regime

Enkhsaikhan Jargalsaikhan

Ph.D., Ambassador Extraordinary and Plenipotentiary, enkhee53@yahoo.com

Abstract

This article examines Mongolia's nuclear-weapon-free status as a unique model for expanding and strengthening the international regime of Nuclear-Weapon-Free Zones (NWFZs) under contemporary geopolitical conditions. It traces the historical evolution of Mongolia's initiative since its announcement at the United Nations General Assembly in 1992 and analyzes the role of the United Nations, the legal framework of the Treaty on the Non-Proliferation of Nuclear Weapons (NPT), the significance of General Assembly resolutions, and the positions of the five nuclear-weapon states (P5). The study further explores the diplomatic consultations surrounding the initiative, including discussions on security assurances, the role of the Non-Aligned Movement, the joint démarche of the Western P3, the Tripartite Consultations in Geneva, and Mongolia–P3 consultations. It also assesses the practical conditions for implementing the initiative and the challenges encountered throughout the negotiation process.

The study argues that Mongolia's single-state nuclear-weapon-free status has complemented and enriched the traditional concept of Nuclear-Weapon-Free Zones by providing a flexible legal and political framework suited to countries whose geopolitical circumstances do not permit participation in regional NWFZ arrangements. The P5 Joint Declaration recognizing Mongolia's status represents an innovative mechanism for providing security assurances outside the conventional treaty-based NWFZ framework. Mongolia's experience demonstrates that a single-state nuclear-weapon-free status can serve as a practical instrument for reinforcing the global nuclear non-proliferation regime and addressing some of the structural limitations of existing Nuclear-Weapon-Free Zones. The article concludes that Mongolia's initiative constitutes an important contribution to the evolution of the international security architecture, eliminates a structural gap in the regime, and offers valuable theoretical and practical insights for strengthening the global non-proliferation regime.

Keywords: Mongolia; Nuclear-Weapon-Free Status; Nuclear-Weapon-Free Zone (NWFZ); United Nations; P5; Nuclear Non-Proliferation Treaty (NPT); Security Assurances; International Law

Received: June 24, 2026 | Accepted: July 01, 2026 | Published online: July 07, 2026



© The Author(s) 2026

<https://creativecommons.org/licenses/by/4.0/>.